



European
Investment
Bank



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2021.01.11


АГУУЛГА

1. Төсөл, арга хэмжээний нэр:	3
2. Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага:	3
3. Төсөл, арга хэмжээний зорилго:	3
4. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	3
5. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр:	3
6. Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт	4
7. Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт	5
8. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ	5
9. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд	6
Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц	6
Хөтөлбөрийн нэг дүгээр үе шат – Баянхошуу, Сэлбэ дэд төв	8
Товч танилцуулга	8
Худалдан авах ажиллагааны явц	11
Барилгын ажлын явц	11
Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	13
Бүрэлдэхүүн 2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламж	17
Бүрэлдэхүүн 3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын менежментийг бэхжүүлэх	18
Бүрэлдэхүүн 4. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх	19
Хөтөлбөрийн хоёр дугаар үе шат – Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төв	29
Товч танилцуулга	29
Худалдан авах ажиллагааны явц	31
Барилгын ажлын явц	32
Бүрэлдэхүүн 1. Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	33
Бүрэлдэхүүн 2. Нийгэм эдийн засгийн барилга байгууламж	34
Бүрэлдэхүүн 3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх	35
Хөтөлбөрийн гурав дугаар үе шат – Толгойт, Шархад дэд төв	43
Товч танилцуулга	43
Худалдан авах ажиллагааны явц	44
10. Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд:	45
11. Тулгамдаж буй асуудлууд:	45
12. Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ:	47
13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:	47
Хөтөлбөрийн хүрээнд дагаж мөрдөж буй бодлогын баримт бичгүүд	48
Хөтөлбөрийн үйл ажиллагааны ил тод байдал	48

1. **Төсөл, арга хэмжээний нэр:** Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр
2. **Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага:** Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)
3. **Төсөл, арга хэмжээний зорилго:** Гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулснаар Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгоход оршино.


“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичигт заасан эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

4. **Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)
5. **Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр:** АХБ-ны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл болон НЗДТГ-ын санхүүжилт



Эх үүсвэр	Хөтөлбөр	I үе шат	II үе шат	III үе шат
АХБ-ны санхүүжилт	163.7	53.7	66.35	43.65
(COL)	70.34	22.5	29.24	18.6
(OCR)	89.66	27.5	37.11	25.05
МОН-0380	3.7	3.7	-	-
НЗДТГ-ын төсөв	120.2	33.15	35.15	51.9
ЕХОБ-ны санхүүжилт	60.3	22.01	19.64	18.65
Нийт	344.2	108.86	121.14	114.2

Төсөл хэрэгжүүлэх дэд төвүүдийн байршил



6. Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт:

2021 оны Улсын төсөв

(төгрөгөөр)

Данс	Дансны нэр	Төсөв	Гүйцэтгэл	%
100900011825	MON-3099 (COL)	3,436,986,784.60	3,436,986,784.60	100.0%
100900011826	MON-3098 (OCR)	8,419,333,070.51	8,419,333,070.51	100.0%
100900011827	EIB FI'83.097	9,995,164,270.45	10,018,270,178.43	100.0%
100900011898	MON-3525 (OCR)	11,417,981,350.74	11,417,981,350.74	100.0%
100900011899	MON-3526 (COL)	20,834,253,925.92	20,834,253,925.92	100.0%
100900011900	EIB FI'83.873	1,121,936,277.79	1,121,936,277.79	100.0%
100900011900	MON-3947 (OCR)	85,447,194.01	85,447,194.01	100.0%
	Нийт	55,334,208,782.00	55,334,208,782.00	100.0%

Нийслэлийн төсөв

(төгрөгөөр)

Данс	Дансны нэр	Төсөв	Гүйцэтгэл	%
100200051324	Хөрөнгө оруулалт - ГЧНШ	241,281,968.00	241,281,968.00	100.0%
100200051324	Хөрөнгө оруулалт - БУА	2,562,441,260.00	2,562,441,260.00	100.0%
	Нийт	2,803,723,228.00	2,803,723,228.00	100.0%

Нийт төсөв

(төгрөгөөр)


Данс	Дансны нэр	Төсөв	Гүйцэтгэл	%
НИЙТ		58,137,932,010.00	58,137,932,010.00	100.0%

7. Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт:

№	Үе шат	Эх үүсвэр	Ашиглалт		
			Батлагдсан (сая ам.доллар)	Зарцуулсан ашиглалт (сая ам.доллар)	%
1	I үе шат (Сэлбэ, Баянхошуу дэд төв)	АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл	75.71	67.16	88.71%
		Нийслэлийн төсөв	33.15	33.03	99.64%
		Нийт	108.86	100.19	92.04%
2	II үе шат (Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төв)	АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл	85.99	29.33	34.11%
		Нийслэлийн төсөв	35.15	3.87	11.01%
		Нийт	121.14	33.20	27.41%
3	III үе шат (Шархад, Толгойт дэд төв)	АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл	62.3	-	0.00%
		Нийслэлийн төсөв	51.9	-	0.00%
		Нийт	114.2	-	0.00%
Хөтөлбөр			344.2	133.39	38.75%

8. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий явцыг дараах байдлаар үзүүлэв



Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нь тайлант хугацаанд 44.06% байгаа бөгөөд энэ нь 2020.12.25-ны өдөртэй харьцуулахад 5.91%-ын өсөлттэй байна. Дараах хүснэгтээс үе шат бүрээр хэрэгжилтийг харна уу

Үе шат	Санхүүжилт	Үйл ажиллагаа	Бодит явц
Үе шат I	108,860,000.00	ТУН байгуулах	100.00%
		Үйл ажиллагаа	97.92%
Үе шат II	121,140,000.00	Үйл ажиллагаа	33.25%
Үе шат III	114,200,000.00	Үйл ажиллагаа	2.46%
		Төслийн хаалт	0.00%
Нийт	344,200,000.00		44.06%

9. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд:

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлыг тэргүүлэгчдийн 2014 оны 107 тоот тогтоолоор Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг анх баталсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/586 тоот захирамжаар Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, Төслийн удирдах хорооны даргаар Нийслэлийн Засаг дарга ажиллаж байна

Монгол улсын сангийн сайдын 2020 оны 155 тоот тушаалаар “Тэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн нийт 27 ажилтантай баталсан .


Төслийн удирдлагын нэгж нь Төслийн зохицуулагч, дэд зохицуулагч 2, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, санхүүгийн мэргэжилтэн 2, гэрээний мэргэжилтэн, нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн 2, байгаль орчны мэргэжилтэн, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ерөнхий инженер, барилгын инженер 2, замын инженер 1, усан хангамж, ариутгах татуургын шугамын инженер 2, цахилгааны инженер, дулааны инженер, хот зохион байгуулалт төлөвлөлтийн мэргэжилтэн, оффис менежер, жолооч 3, МТ-ийн мэргэжилтэн гэсэн нийт 27 хүний орон тоотой төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь харилцан хамаарал бүхий дараах үйл ажиллагаануудаас хамаарна. Үүнд:

1. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт – төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд хийгдэх газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны хамгааллын бодлогыг дагаж мөрдөх үүргийг МУ-ын тал гэрээгээр хүлээсэн байна. Иймд, төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын ажлуудын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан, АХБ-аар батлуулснаар тухайн батлагдсан төлөвлөгөөний дагуу газар чөлөөлөх ажлыг хэрэгжүүлнэ.
2. Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах – газар чөлөөлөлтийн ажлыг гүйцэтгэн газрын гэрчилгээ гарснаар барилгын тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу тухайн баригдах объектод техникийн нөхцөлүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч зураг төслийг эцэслэн боловсруулна. Зураг төслийн ажил дууссанаар төслийн худалдан авах ажиллагааг эхлүүлэх боломж бүрддэг.
3. Төслийн худалдан авах ажиллагаа – төслийн баримт бичигт зааснаар төслийн хүрээнд хийгдэх бараа материал, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг АХБ-ны

худалдан авах ажиллагааны журмын дагуу АХБ-аас баталсан төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу АХБ-ны зохих хяналттайгаар зохион байгуулна.

4. Төслийн үйл ажиллагаа – төслийн хүрээнд хийгдэх барилга угсралтын аливаа бүх ажлууд нь төслийн худалдан авах ажиллагаа, газар чөлөөлөлт бүрэн дууссанаар хэрэгжиж эхлэх бөгөөд барилгын ажлын явцад хяналт тавьж үр шим хүртэгчид хүлээлгэн өгнө.



Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт заасны дагуу АХБ-ны худалдан авах ажиллагааны журам, Хамгааллын бодлогын баримт бичиг болон АХБ-ны холбогдох журмуудыг баримтлан ажилладаг.

	Үе шат-1	Үе шат-2	Үе шат-3
Төслийн хугацаа:	2014.09.30 – 2021.12.30	2018.03.14 – 2023.12.11	2021.03.15-2023.12.11

Хөтөлбөрийн нийт төлөвлөсөн хэрэгжүүлэх хугацааны 80.41% нь буюу 98 сар өнгөрөөд байгаач дараах зайлшгүй нөхцөл байдлуудын улмаас төслийн хэрэгжилтийн явц удаашраад байна. Үүнд:

- Хөтөлбөрийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төсөв хөрөнгө дутмаг
- Дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлаас сэргийлэх Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн хүрээнд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдтэй уулзалт зохион байгуулах, зөвшилцөх ажлыг сүүлийн 2 жилийн хугацаанд зохион байгуулах боломжгүй болсон.
- Мөн энэхүү цар тахлын тархалт улам ихсэж байгаатай холбогдуулан олон нийтийн хөл хорио тогтоон барилгын ажлыг зогсоосон мөн бараа материал татан авалтад хугацаа их зарцуулж байна. (2020 оны 11 сард Ковид19-ын анхны тохиолдолд бүртгэгдсэнээс хойш нийт 7 удаагийн нийт 78 хөл хорио тогтоосон бөгөөд 2020 оны 1 сараас эхлэх хилийг хааж бараа материал нэвтрүүлэхэд хүндрэл ихтэй удаашралтай болсон.)
- Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор барилгын материалын үнэ огцом өсөж 2020 он болон түүнээс өмнө байгуулсан барилгын ажил үргэлжилж байгаа ажлуудын төсөвт өртөг огцом өссөн байгаа нт барилгын ажил удааширч төслийн хэрэгжилтийг удаашруулахад нөлөөлж байна.
- Барилга угсралтын ажлын өвлийн нөхцөл, технологитой холбоотойгоор өвлийн турш ихэнх ажил сул зогсолт хийсэн.

- Зээлийн хэлэлцээрт заасан Нийслэлийн хариуцах барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт олгогдохгүй хугацаа хоцорч байна.
- Нийслэлийн төсөв тасарснаас 2020 оны 9 сараас эхлэн Нийслэлийн хариуцах барилга угсралтын ажлын төлбөрүүд төлөгдөх боломжгүй болсон.

Мөн тайлант хугацаанд АХБ-ны ажлын хэсэг төслийн хэрэгжилтэд хяналт тавин 2021.06.04-нөөс 29-ны хооронд ажилласан бөгөөд төслийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг холбогдох талуудтай хэлэлцэн хугацаа одоогийн нөхцөл байдлаас шалтгаалан хоцорч байгаа хугацааг хэрхэн нөхөх хөрөнгө оруулалтуудыг хэрхэн дахин хуваарилах талаар саналаа солилцсон бөгөөд Хяналтын ажлын хэсгийн хүрээнд санамж бичиг зурахаар хамтран ажиллаж байна.

ХӨТӨЛБӨРИЙН НЭГ ДҮГЭЭР ҮЕ ШАТ – БАЯНХОШУУ, СЭЛБЭ ДЭД ТӨВ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баянхошуу дэд төвд хамаарах Сонгинохайрхан дүүргийн 7,8,9,10,11,28,40 дүгээр хороонд нийт 162 га газар, Сэлбэ дэд төвд хамаарах Сүхбаатар дүүргийн 13,14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 14,18 дугаар хорооны 156 га газар нутаг байна.

Хөтөлбөрийн 1 үе шатыг дараах зорилтуудад хүрэхийн төлөө хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг инженерийн дэд бүтцээр бүрэн хангаж, хотын дэд төв болон хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх арга механизмыг тодорхойлон хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу талуудын харилцан тохиролцсон Олон шатлалт санхүүжилтийн зээлийн удирдлагын баримт бичиг (ОШСЗУББ)-т тодорхойлсны дагуу Төсөл 1-ийн нийт санхүүжилт 104.5 сая ам.доллар ба үүний 53.7 сая ам.доллар буюу 51.38%-ийг АХБ, 28.38 сая ам.доллар буюу 27.15%-ийг ЕХОБ, үлдсэн 22.42 сая ам.доллар буюу 21.45%-ийг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн. Төслийн дунд хугацааны хяналт үнэлгээг АХБ-аас 2017 оны 02 дугаар сард хийсэн ба энэ үеэр төслийн зардлын тооцооллыг шинэчилсэн. Шинэчилсэн тооцооллоор Төсөл 1-ийн нийт санхүүжилт 108.86 сая ам. доллар ба үүний 53.7 сая ам.доллар буюу 49.33%-ийг АХБ, 22,01 сая ам. доллар буюу 20.22%-ийг ЕХОБ, үлдсэн 33.15 сая ам. доллар буюу 30.45%-ийг НЗДТГ хариуцна. Төслийн зардлын таамаглалыг дор дэлгэрэнгүй үзүүлэв.

Төслийн хөрөнгө оруулалтын шинэчилсэн төлөвлөгөө

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт		Эзлэх хувь
	Анхны төлөвлөсөн	Шинэчлэгдсэн	
АХБ-ны санхүүжилт			
МОН-3099 (COL)	22.5	22.5	20.67
МОН-3098 (OCR)	27.5	27.5	25.26
МОН-0380 (COL)	3.7	3.7	3.4
Дэд дүн	53.7	53.7	49.33
НЗДТГ-ын төсөв	22.44	33.15	30.45
ЕХОБ-ны санхүүжилт FI'83097	28.38	22.01	20.22
Нийт	104.52	108.86	100

№	Үндсэн үйл ажиллагаа	Эхний таамаглал	Шинэчлэгдсэн	Өсөлт /Бууралт	
				Мөнгөн дүнгээр	Хувиар
А. Суурь зардал		93.13	97.47	4.34	4.66%
I	Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	80.43	84.77	4.34	5.40%
1.1	Автозам сайжруулах	24.59	28.93	4.34	17.65%
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	25.70	25.70	0.00	0.00%
1.3	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	30.14	30.14	0.00	0.00%
II	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үр ашгийг нэмэгдүүлэх	3.70	3.70	0.00	0.00%
III	Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх	5.00	5.00	0.00	0.00%
IV	Байгууллагыг чадавхижуулах	4.00	4.00	0.00	0.00%
4.1	Хөтөлбөрийн менежментийн дэмжлэг	2.00	2.00	0.00	0.00%
4.2	Үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжих	0.50	0.50	0.00	0.00%
4.3	Дэд төвийн хөгжил ба иргэдийн оролцоог хангах	1.50	1.50	0.00	0.00%
Б. Магадлашгүй ажил		7.39	7.39	0.00	0.00%
В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж		4.00	4.00	0.00	0.00%
Нийт дүн		104.52	108.86	4.34	4.15%

Төслийн зардал нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн зардал анх таамаглаж байсан 1.02 сая ам.доллараас 10.49 сая ам.доллар болж өссөн үзүүлэлт болно. Төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн болон нийгмийн байгууламжуудын байршлыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн тодорхойлсоноор төслийн хүрээнд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтэд өртөх нэгж талбарын тоо хэмжээ тодорхой болсон ба үүнд хамаарах нөхөн олговрын зардлыг илүү бодитой таамаглах нөхцөл бүрдсэнтэй холбоотой.

Хөтөлбөрийн 1-р үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх
4. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийг бүтээн байгуулалтын ажлыг 2021 онд бүрэн дуусгахаар төлөвлөсөн бөгөөд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан ажлын хэрэгжилтийн явц удаашралтай байна. 1-үе шатны хэрэгжилтийн явц 97.92% байна.

Үйл ажиллагаа	Бодит явц
ГЧНШ	100%
ХАА	100%
Барилгын ажил	100%
Зөвлөх үйлчилгээ	100%
Бараа	100%
Барилга угсралт	96.60%
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	94.54%
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	99.66%
Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менежментийг бэхжүүлэх	100.00%
Усны барилга байгууламжууд	92.70%
Зөвлөх үйлчилгээ	99.20%
Нийт	97.92%

Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн тоймыг дараах хүснэгтээс харна уу

Барилга байгууламж	Баянхошуу дэд төв	Сэлбэ дэд төв
Автозам	6.5 км төлөвлөснөөс 6.1 км хийгдсэн	7.6 км төлөвлөснөөс 7 км хийгдсэн
Цахилгааны шугам сүлжээ	6.3 км төлөвлөснөөс 6.3 км хийгдсэн	2.4 км төлөвлөснөөс 2.4 км хийгдсэн
Дулаан хангамжийн шугам сүлжээ	16.8 км төлөвлөснөөс 16.2 км хийгдсэн	8.7 км төлөвлөснөөс 8.5 км хийгдсэн
Ус хангамжийн шугам сүлжээ	10.9 км төлөвлөснөөс 10.7 км хийгдсэн	7 км төлөвлөснөөс 7 км хийгдсэн
Ариутгах татуургын шугам сүлжээ	16.6 км төлөвлөснөөс 16.2 км хийгдсэн	11.5 км төлөвлөснөөс 11.2 км хийгдсэн
Үерийн хамгаалалтын далан суваг	4.7 км төлөвлөснөөс 4.7 км хийгдсэн	2.2 км төлөвлөснөөс 2.2 км хийгдсэн
Харилцаа холбооны шугам сүлжээ	2.9 км төлөвлөснөөс 2.9 км хийгдсэн	2.8 км төлөвлөснөөс 2.8 км хийгдсэн
Талбайн тохижилт	4.65 га талбайн ажил – 100%	3.01 га талбайн ажил – 95%
Усан сан	1000м3 усан сан, 2ш насос станц - 100%	1000м3 усан сан, 1ш насос станц - 100%
Төмөр бетон гүүр	-	3ш /60м, 30м, 24м/ – 100%
Дулааны станц	-	26 МВт – 90.75%
Мэдээлэл холбооны үйлчилгээний нэгдсэн төв	1ш – 100%	1ш – 100%
Бизнес инкубатор, сургалтын төв	1ш – 100%	1ш – 100%
Цэцэрлэг	240 хүүхдийн ортой, 1ш – 100%	240 хүүхдийн ортой, 1ш – 100%
Орлогд нийцэн орон сууц	20 айлын орон сууц – 95%	-

Барилгын ажлын дэлгэрэнгүй мэдээллийг барилгын ажлын явц хэсгээс харна уу

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Хөтөлбөрийн 1 үе шатны худалдан авалтын төлөвлөгөөнд АХБ-ны хүсэлтийн дагуу 2021.07.06-нд өөрчлөлт оруулан шинэчлэгдэн батлагдсан бөгөөд энэхүү худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 32 барилгын ажил, 16 зөвлөх үйлчилгээ, 11 бараа худалдан авалтын нийт 59 ажлын худалдан авалтыг 4 эх үүсвэрээс санхүүжүүлэхээр бүрэн зохион байгуулж дууссан байна.



Гэрээ байгуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт 1-т** үзүүлэв

БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ


Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хүрээнд нийт 32 барилгын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажлууд дуусах шатандаа явж байна. Дэлхий нийтээр тархаад байгаа Корона вирусны цар тахлаас сэргийлэх Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хүрээнд Нийслэлийн төсөв тасран зээлийн хэлэлцээрийн дагуу Нийслэлийн төсвөөс санхүүжих барилгын ажлуудын төлбөрийг төлж чадаагүйгээс барилгын ажлууд удаашраад байна.

Энэхүү үе шатны хүрээнд АХБ-ны буцалтгүй тусламжаар 1, АХБ-ны санхүүжилтээр 9, АХБ болон Нийслэлийн хамтарсан санхүүжилтээр 9, ЕХОБ-ны санхүүжилтээр 13 барилгын ажлыг гүйцэтгэн ажиллаж байгаагаас нийт 26 барилгын ажлын улсын комиссыг ажиллуулан зарим барилгын ажлуудыг холбогдох ашиглагч байгууллагад хүргүүлээд байна.

№	Барилгын ажлын нэр	Улсын комисс ажилласан огноо	Хөрөнгөд бүртгэсэн огноо/ захирамж дугаар
АХБ-ны санхүүжилт			
1	WFOI: Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах ажил	11/28/2018 № 2018/650	3/17/2020-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
2	BSF05 Багц1: Баянхошуу дэд төвд баригдсан 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга	12/11/2018 №2018/737 12/7/2018 №2018/709	7/3/2020 НЗД-ын А/936 тоот захирамж
3	BSF05 Багц2: Баянхошуу дэд төвд баригдсан бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга	6/21/2019 №2019/200	4/23/2020 НЗД-ын А/565 тоот захирамж
4	BHF06: Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	09/18/2019 №2018/358	10/8/2020 ТӨБЗГ-ын 477 дугаартай захирамжаар хөрөнгө бүртгэсэн

5	SSF05 Багц1: Чингэлтэй дүүргийн 18-р хороо, Сэлбэ дэд төвд баригдсан 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга	8/27/2020 №БА-016/2020	3/9/2021 НЗД-ын А/135 тоот захирамж
6	SSF05 Багц2: Чингэлтэй дүүргийн 18-р хороо, Сэлбэ дэд төвд баригдсан бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга	9/9/2020 № БА-027/2020	9/6/2021 НЗД-н А/685 тоот захирамжаар хөрөнгөөр бүртгэсэн
7	SBR08: 24м, 30м, 60м урттай, төмөр бетон 3ш гүүр	12/7/2020	Гүйцэтгэгч байгууллагаас эцсийн гүйцэтгэлийг авсны дараа НӨАУГ-т хүлээлгэн өгөх материалыг бэлтгэнэ
8	BSLS09 Багц1: Баянхошуу дэд төвийн 4.65 га талбайн тохижилтын ажил	8/27/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
9	SRDH14: Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 2	9/7/2021 10/18/2021 10/19/2021 10/21/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
10	BSLS09 Багц 2: Сэлбэ дэд төвд үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил	10/18/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
11	BEC13: Баянхошуу дэд төвийн цахилгаан болон холбооны шугам сүлжээний барилга угсралтын ажил	09/27/2021	Холбооны болон цахилгааны шугам сүлжээний ажилд улсын комисс ажилласан бөгөөд бусад ажлуудад улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.
12	BRDH14: Баянхошуу дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 2	09/27/2021	Авто зам, УДДТ, холбооны болон цахилгааны шугам сүлжээний ажилд улсын комисс ажилласан бөгөөд бусад ажлуудад улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.
13	BRDH11: Баянхошуу дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 1	11/16/2021 12/20/2021	Ус хангамж, ариутгах татуурга дулааны шугам сүлжээний ажилд улсын комисс ажилласан бөгөөд бусад ажлуудад улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.
14	SRDH11: Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 1	11/16/2021	
ЕХОБ-ны санхүүжилт			
15	BCM1: 4116 Метр DM450&500-ийн зөөлөн ширмэн (3ш) хоолойтой Баянхошууны 1-р	12/21/2016 №2016/625	3/26/2021-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн

	хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил		
16	BCM2: Баянхошууны ариутгах татуургын 2-р хэсгийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн (3ш) хоолой бүхий ариутгах татуургын шугамын барилгын ажил	10/24/2017 №2017/283	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
17	SCM: Сэлбийн 2183 М DN400-ийн зөөлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын ажил	12/28/2017 №2017/605	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
18	BSDF07 Багц1: Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил	11/19/2018 №2018/617	8/20/2020-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
19	BSDF07 Багц2: Сэлбэ дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажил	12/5/2018 № 2018/690 9/10/2020 № БА-030/2020	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол хүлээгдэж байна
20	WSNR17C: Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил	7/16/2019 № 246	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
21	WWTPR01: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил	7/22/2019 № 2019/255	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
22	BSWR10 Багц2: Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил	11/29/2019 №2019/783 10/21/2019 № 2019/483	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
23	BSWR10 Багц1: Баянхошуу дэд төвийн 1000м3 усан сан, насос станц, ус дамжуулах шугам	9/11/2020 № ШС-34/2020	НХОГ-аас 2021.08.04 -с НӨАУГ-т хүсэлт хүргүүлсэн
24	WSNR16A: Салбар шугамын холболт	08/13/2021	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
25	BSDF07B: Баянхошуу Үерийн хамгааллын суваг, шинэ	11/18/2021	



Барилгын ажлын дэлгэрэнгүй мэдээллийг дараах хэсэг хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр дараах байдалтай байна.

БҮРЭЛДЭХҮҮН 1. АВТО ЗАМ БОЛОН ХОТЫН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт нь дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн суурь үйлчилгээ (ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж)-г өргөжүүлэн,

тэдгээрийн хоорондын холболтыг сайжруулснаар хотын орон зайн хэв шинжийн өөрчлөлтийг эхлүүлэх бөгөөд энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд АХБ болон ЕХОБ-ны санхүүжилтээр хийгдэх 22 ажлын гэрээг байгуулан барилгын ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн барилгын ажлын явцыг дараах хүснэгтээр үзүүлж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц
АХБ-ны санхүүжилт				
1	BHF06	Дулааны шугамын өргөтгөл шинэчлэл	3.2 км дулааны шугам	100.0%
2	BRDH11	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	Цэвэр усны шугам, 2976м Бохир усны шугам, 3915м Автозам, гэрэлтүүлэг, гадаргын ус зайлуулах шугам, 2885м Холбооны шугам зөөж шилжүүлэх, 29ш Цахилгааны шугам зөөж шилжүүлэх, 3210м Дулааны шугам, 7432м Ус дулаан дамжуулах төв, 6ш	100.0%
3	BRDH14	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 2	Цэвэр усны шугам, 2170м Бохир усны шугам, 4566м Автозам, гэрэлтүүлэг, гадаргын ус зайлуулах шугам, 3653м Холбооны шугам зөөж шилжүүлэх Цахилгааны шугам зөөж шилжүүлэх Дулааны шугам, 3450м Ус дулаан дамжуулах төв, 6ш Зөөж шилжүүлсэн 6х6м ус түгээх байр Ус дулаан дамжуулах төв, 6ш	95%
4	BEC13	Баянхошуу Цахилгаан, холбооны шугам сүлжээ	35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам, 4000м 2*16/35/10МВА-ын цахилгааны дэд станц 10 кВ хуваарилах байгууламж 10 кВ кабелийн шугам, 2300м 2*630/10/0.4кВА хаалттай дэд өртөө, 2ш Холбооны худаг, сувагчлал, шилэн кабель, 2948м Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв	98%
5	SBR08	Сэлбэ дэд төвийн Гүүр	24м, 30м, 60м төмөр бетон гүүр	100.0%
6	SHF06	Сэлбэ Дулааны станц, 26МВт, 1ш	Сэлбэ дэд төвийн 28МВт-н Дулааны станц	91%
7	SRDH11	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	Цэвэр усны шугам, 2100м Ариутгах татуургын шугам, 5003м Автозам, гэрэлтүүлэг, гадаргын ус зайлуулах шугам, 4710м Холбооны шугам зөөж шилжүүлэх Цахилгааны шугам зөөж шилжүүлэх Гадна дулааны шугам, 4042м Ус дулаан дамжуулах төв, 8ш	100.0%
8	SRDH14	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын	Цэвэр усны шугам, 1870м Бохир усны шугам, 4270м	100.0%

		шугам сүлжээ - үе шат 2	Автозам, гэрэлтүүлэг, гадаргын ус зайлуулах шугам, 1888м Холбооны шугам зөөж шилжүүлэх Цахилгааны шугам зөөж шилжүүлэх Дулааны шугам, 4654м Ус дулаан дамжуулах төв, 6ш	
9	SEC13	Сэлбэ Цахилгаан, холбооны шугам сүлжээ	35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам, 1935м 2*16/35/10МВА-ын цахилгааны дэд станц 10 кВ кабелийн шугам, 549м 2*630/10/0.4кВА хаалттай дэд өртөө, 2ш Холбооны худаг, сувагчлал, шилэн кабель, 2768м Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв	98%
ЕХОБ-ны санхүүжилт				
10	BCM1	Баянхошууны 1-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын ажил	Ариутгах татуургын шугам, Ф450-500, 4116м	100.0%
11	BCM2	Баянхошууны 2-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил	Ариутгах татуургын шугам, Ф600 2250м	100.0%
12	SCM	Сэлбэ Бохирын гол шугам	Ариутгах татуургын шугам, Ф400, 2183м	100.0%
13	BSDF07 Lot 1	Үерийн хамгаалал, далан суваг	Үерийн хамгаалалтын суваг, сувгийн хамгаалалтын хайс, 2400м	100.0%
14	WSNR17C	Орос 14-өөс төвийн шугам	Ариутгах татуургын шугам, Ф400, 543м	100.0%
15	WWTPR01	Төв цэвэрлэх шинэчлэл	Төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн засвар	100.0%
16	BSWR10 Lot 2	Усан сан	Усан сан 1000м ³ , Насос станц, Өргөлтийн насос станц, ус дамжуулах хоолой, Дизель генератор Гадна цахилгааны КТПН /1*100кВА/	100.0%
17	BSDF07 Lot 2	Үерийн хамгаалал, далан суваг	Үерийн хамгаалалтын суваг, сувгийн хамгаалалтын хайс, 2200 м	100.0%
18	WSC16A	Салбар шугамын холболт	Дулааны шугам, 2800м Ариутгах татуургын шугам, 1800м	100.0%
19	BSWR10 Lot 1	Баянхошуу Усан сан	Усан сан 1000м ³ , Насос станц, Өргөлтийн насос станц, ус дамжуулах хоолой, Дизель генератор Гадна цахилгааны КТПН /1*100кВА/	100.0%
20	BSDF07B	Баянхошуу Үерийн хамгаалалтын суваг, шинэ	Үерийн хамгаалалтын суваг, сувгийн хамгаалалтын хайс, 2300м	100.0%
21	WSNR17A	Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх	Ус дамжуулах шугам Ф900мм-н 4010м, Ариутгах татуургын шугам Ф600мм-н 1684м	60%

22	WSNR17B	Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 7054м	Ус дамжуулах шугам Ф600мм-н 8070м,	84%
----	---------	--	------------------------------------	-----

Дээрх хүүлэгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.

1. Баянхошууны 1, 2-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр СХД-ийн 4.5.7.8.9.10.11.18.26 хорооны хэрэглэгчдийн айл өрх албан байгууллагын бохир усыг татан зайлуулж цаашдаа хөрсний бохирдол багасах, эрүүл ахуйн нөхцөл сайжрах, усны зохистой хэрэглээ бий болох, байгаль орчинд эерэг сайн нөлөө үзүүлэх нөхцөл байдлууд үүсэж эхэлнэ.
2. Сэлбэ дэд төвийн бохирын шугам сүлжээний барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр Сэлбэ дэд төвийн Чингэлтэй талын хэрэглэгчдийн айл өрх албан байгууллагын бохир усыг татан зайлуулж цаашдаа хөрсний бохирдол багасах, эрүүл ахуйн нөхцөл сайжрах, усны зохистой хэрэглээ бий болох, байгаль орчинд эерэг сайн нөлөө үзүүлэх нөхцөл байдлууд үүсэж эхэлнэ.
3. Баянхошуу дэд төвд нийт 2,3 км үерийн хамгаалалтын сувгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэснээр үерийн улмаас гудамж талбайд ус тогтох болон оршин суугчид усанд автахаас сэргийлсэн байна.
4. Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр одоо ашиглагдаж байгаа шугам сүлжээний хүчин чадал нь барилгажих явцад хүрэлцэхгүй болсон байсныг өргөтгөн шинэ барилгуудыг шугам сүлжээнд холбох боломжтой болоод байна.
5. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:
 - Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн насжилтыг 20-25 жил уртасгасан.
 - Цэвэрлэгээний төвшин 2-10 хувь дээшилсэн.
 - Байгаль орчинд учруулах бохирдолтын хэмжээг багасгасан.
6. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

Ханын материал, Баянхошуу орчмын барилга байгууламж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөл бүрдэж, шинээр дулааны магистраль шугам Баянхошуу дэд төв рүү татах боломж үүссэн.
7. Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дэд төвүүдийг найдвартай усны эх үүсвэртэй холбож өгч байна
8. Сэлбэ дэд төвд нийт 2,4 км үерийн хамгаалалтын сувгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэснээр үерийн улмаас гудамж талбайд ус тогтох болон оршин суугчид усанд автахаас сэргийлсэн байна.

БҮРЭЛДЭХҮҮН 2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт нь хүн амын эрэлтийг хангахуйц, хотын функц ба ач холбогдлыг өндөржүүлэхүйц, ажлын байр бий болгохуйц хөрөнгө оруулалтыг нийгэм, эдийн засгийн байгууламжид хийснээр төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бөгөөд энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 9 барилгын ажлын гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн барилгын ажлын явцыг дараах хүснэгтээр үзүүлж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц
1	BSF05 Lot 1	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	261-р цэцэрлэгийн барилга болон гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт, зам талбай Гадна цахилгааны КТПН /1*400кВА/	100.0%
2	BSF05 Lot 2	МСҮТ, бизнес инкубаторын барилга	Баянхошуу дэд төвийн Бизнес инкубатор, МСҮТ-ийн барилга болон гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт, зам талбай Гадна цахилгааны КТПН /1*400кВА/	100.0%
3	SSF05 Lot 1	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	Сэлбэ дэд төвийн цэцэрлэгийн барилга болон гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт, зам талбай	100.0%
4	SSF05 Lot 2	МСҮТ, бизнес инкубаторын барилга	Сэлбэ дэд төвийн цэцэрлэгийн барилга болон гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт, зам талбай	100.0%
5	BSLS09 Lot 1	Баянхошуу Тохижилт, ландшафт	4.65 га Баянхошуу дэд төвд үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил	100.0%
6	PP01-SW	Баянхошуу дэд төвд Орлогд нийцсэн орон сууцны туршилт	2 блок 20 айлын орон сууцны барилга	95%
7	TFBA	Чөлөөлсөн талбайг хашаалах	Чөлөөлсөн талбайг хашаалах НОСК, 1500м	100.0%
8	BSLS09 Lot 2	Сэлбэ Тохижилт, ландшафт	3.01га Сэлбэ дэд төвд үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил	100.0%
9	SCBA	Баянхошуу дэд төвд талбай цэвэрлэх		100.0%

Дээрх хүлээлгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.

1. Баянхошуу дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

2018 оны 12-р сард ашиглалтанд орж, үйл ажиллагаагаа эхлүүллээ. Ингэснээр, тус дэд төвийн цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан 331 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, нийт 41 багш ажилчид ажлын байртай боллоо.

2. Баянхошуу дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

2020 оны 3 сард Баянхошуу Бизнес Инкубатор төв нээлтээ хийж, иргэдэд үйлчилж эхэлсэн бөгөөд 2020 оны 12-р сарын эцсийн байдлаар Нийслэлийн үйлчилгээний

нэгдсэн төв, Баянхошуу салбар, нийт 198 төрлийн төрийн үйлчилгээ, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний төвийн салбар, Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, инкубатор өрөөнд бойжигчид, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Иргэдийн мэдээллийн төв, Азийн Сангийн Бизнес Эрхлэгч эмэгтэйчүүдийн төв, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, Дэлхийн Зөн, Төгсөлтийн аргачлал-600, зорилтот өрхийн бүлэг, Дэд төвийн хороодын бизнес эрхлэгч иргэд(үсчин, үндэсний гутал хийдэг гэр бүл) гэх мэт байгууллага, иргэд үйл ажиллагаагаа явуулж, нийт 37 хүн байнгын ажлын байртай боллоо.

3. Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

2020 оны 9-р сард ашиглалтанд орж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд тус дэд төвийн цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй байсан 265 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, нийт 38 багш ажилчид ажлын байртай боллоо.

4. Сэлбэ дэд төвд барих МСҮТ, бизнес инкубатор төвийн барилгын угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

2020 оны 9 сард нээлтээ хийж, одоогоор Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төвийн 9 ажилтан ажиллаж байна.

Дээрх 2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдсэн барилгын ажлын зургуудыг **Хавсралт 2-т** үзүүлэв.

БҮРЭЛДЭХҮҮН 3. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилт нь ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн үйлчилгээг сайжруулснаар үйлчилгээний байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх бөгөөд АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах 3,370 сая ам долларын гэрээг Комфорт импекс ХХК, Хунан шаню ХХК-ын түнлэлтэй байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

Уг буцалтгүй тусламжийн дэд төсөл хэрэгжсэнээр УСУГ-т нэгдсэн удирдлагын СКАДА систем байгуулж, үүнд шаардагдах тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулснаар усны алдагдлыг илрүүлэх зэргээр үйл ажиллагааны горимыг сайжруулж, ус, эрчим хүчний хэмнэлт үүсгэн ашиглалтын зардлыг бууруулахаар төлөвлөгдсөн бөгөөд энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Үйлдвэр, Мах, Төв болон гаурт насос станцуудын тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн
- Үйлдвэрийн насос станцад 1 өргөгчийн насос станцын гүний худгийн 16 ширхэг насосыг иж бүрнээр нь шинэчлэн суурилуулсан
- Төвийн насос станцын эх үүсвэрийн 2 өргөгчийн 4 насос, 6 кВ-ын давтамж хувиргагчийг барилгын хамт барьж ашиглалтанд оруулсан
- Түгээх сүлжээний хяналтын 30 болон хэмжих 40 худгуудын барилга угсралтыг гүйцэтгэсэн
- УСУГ-ын удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдал илрүүлэх систем суулгасан
- Нэгдсэн удирдлагын программ хангамжыг суурилуулан ашиглалтад оруулсан.
- Нийт 39,7 мянган м урт шилэн кабель суурилуулсан
- Төвийн эх үүсвэрийн 6кВ-ын 750кВт-ын хүчин чадал бүхий цахилгаан хөдөлгүүрт давтамж хувиргагч суурилуулснаар 3 насос хөдөлгүүрийг удирдан ажиллах бүрэн боломжтой болсон

Үүний үр дүнд өмнөх 3 жилийн дунджаар 1м3 ус усыг 0,64кВт/цаг эрчим хүчээр олборлон түгээдэг байсан бол 2018 онд 0,51кВт/цаг болж 0,12 кВт/цагийн эрчим хүчний хэмнэлттэй ажиллаж эхэлсэн байна. Гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг **Хавсралт 3-т** үзүүлэв.

БҮРЭЛДЭХҮҮН 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Энэ бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж барилгын ажлуудтай холбоотой болон хот төлөвлөлт, дэд төвүүдийн хөгжлийг боловсронгуй болгох, дэд төвийн бүтээн байгуулалтын талаарх иргэдийн ойлголтыг төлөвшүүлэх, тэдний оролцоог хангах, дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх юм.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна

АХБ-НЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Энэ үе шатны хүрээнд төлөвлөгдсөн байсан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил бүрэн хэрэгжсэн бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна.

1. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ болон нийгмийн барилга байгууламжийн барилгын ажлын нөлөөлөлд өртсөн нийт 1229 нэгж талбар байгаагаас, иргэдтэй зөвшилцөн 1223 айл өрх иргэд нөхөн төлбөрөө бүрэн хүлээж авсан байна.

Байршил /дэд төв/	Ажлын нэр	Нөлөөлөлд өртсөн нэгж талбарын тоо				Нөхөн төлбөр төлөгдсөн өрхийн тоо	Нийт нөхөн олговор
		Нийт	бүтэн	хагас	Газрын эрхгүй өрхүүд		
Баян-хошуу	Авто зам, инженерийн шугам сүлжээ	447	130	211	106	447	12,903,381,467
	Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ-ын дэд өртөө	27	27	0	0	27	2,270,437,005
	Усан сан	11	9	2	0	11	293,491,344
	Бохир усны коллекторын ажил	104	15	89	0	104	1,146,487,178
	Дулааны төвлөрсөн дулаанд холбох шугам	59	16	35	8	59	1,535,126,627
Бүгд		648	197	337	114	672	18,148,923,621
Сэлбэ	Авто зам, инженерийн шугам сүлжээ	492	190	154	148	486	18,104,299,308
	Дулааны станц	28	27	0	1	28	2,160,010,339
	Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ-ын дэд өртөө	26	26	0	0	26	2,285,557,375
	Бохир усны коллекторын ажил	19	0	19	0	19	96,051,731
Бүгд		565	243	173	149	559	22,645,918,753
КТМС-с Талх чихэр хүртэлх цэвэр болон бохир усны 11 км шугам		16	5	10	1	16	308,695,254
Нийт		1229	445	520	264	1223	41,103,537,628

2. Нөлөөлөлд өртөн газраа хагас чөлөөлсөн нийт 317 нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг Нийслэлийн газрын мэдээллийн санд оруулж нийт 278 нэгж талбарын кадастрын зураглал, газрын гэрчилгээг иргэдэд олгоод байна.

Дэд төв	Эдэлбэрийн хэлбэр	Шинэчилсэн гэрчилгээ авах иргэдийн тоо	Шинэчилсэн гэрчилгээний тоо	Шинэчилсэн гэрчилгээ хүлээн авсан иргэдийн тоо	УБХ дээр материал хүлээгдэж байгаа	ДГЗБА хүлээгдсэн	Иргэнээс хамааралтай хүлээгдсэн
Баянхошуу	Өмчлөх	184	170	170	12		2
	Эзэмших	19	12	12		7	
	Нийт	203	182	182	12	7	2
Сэлбэ	Өмчлөх	101	94	91		2	5
	Эзэмших	13	2	2		11	
	Нийт	114	96	93	0	13	5

3. Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй нийт 266 өрх байсан бөгөөд тэдэнд суурь дэд бүтцээр хангагдсан нийтийн үйлчилгээтэй газар олгох эсвэл зорилтот бүлгийн орон сууц санал болгох зэрэг боломжит хувилбаруудыг санал болгон баталгаажуулж, тухайн иргэдтэй зөвшилцөн сонгосон хувилбаруудыг Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 2020.03.12-ны өдөр хэлэлцүүлж, хурлын шийдвэрийн дагуу боломжит газруудын эзэмшлийг өөрчлөн Нийслэлийн Засаг даргын А/421, А/422 тоот захирамжуудыг батлуулсан.
4. НЗД-ийн 2021 оны А181 дүгээр захирамжаар Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Морингийн даваанд нийт 189 иргэнд газар эзэмшүүлэх захирамж гарсан ба үүнээс 184 иргэний гэрчилгээ олгогдоод байна.Үлдсэн иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулах тухай албан тоотыг НГЗБА-нд НЗДТГ-аар дамжуулан 2021 оны 07 дугаар сарын 6-нд хүргүүлсэн байна

Дэд төв	Нийт	37 байршил газар сонгосон	Морин даваанд газар сонгосон	Газар сонгохгүй гэсэн	Түрээслээд өмчлөх байр сонгосон	Газар сонгоогүй
Баянхошуу	98	25	47	2	13	11
Сэлбэ	155	55	67	4	21	8
Нийт	253	80	114	6	34	19

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/675 дугаар захирамжийн дагуу иргэдийн гэрчилгээ кадастрын зургийг нэн яаралтай гаргаж өгөх тухай 2020.07.01-ний өдрийн 952 тоот албан бичгийг Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын албанд хүргүүлсэн ба үүнээс хойш Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1214 дүгээр газар эзэмших эрх олгох тухай захирамж батлагдсан.

2020 болон 2021 оны Нийслэлийн төсөв тасарснаас газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн төлбөрүүд удаашран газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа зогссон байсныг АХБ-тай зөвшилцөн газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн төлбөрийг зээлийн хөрөнгөнөөс гаргахаар талууд тохиролцон Засаг даргын 2021 оны 6 сарын 31-ны өдрийн А/526 тоот захирамжаар газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг зээлийн хөрөнгөнөөс санхүүжүүлж эхэлсэн

Байгаль орчны хамгааллын үйл ажиллагаа

Төслийн 1 дүгээр үе шатны Сэлбэ, Баянхошуу дэд төвийн 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 дугаар журмын дагуу боловсруулж, БОАЖЯ-аар 2 тайланг батлуулсан.

Төслийн 1, 2 дугаар үе шатны 21 гүйцэтгэгч нарын байгаль орчны холбогдох бичиг баримтын бүрдлийн шалгаж, дутуу баримт бичгийг нөхөж авах шаардлага хүргүүлж баримт бичгийн нийцлийг шалган ажилласан. Үүнд хог хаягдлын гэрээ, цахилгааны гэрээ, усны гэрээ, хайрга чулууны гэрээ гэх мэт орно.

“Гүйцэтгэгч” компаниудын ажилд 3 дугаар сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд тогтмол байгаль орчны хяналтыг тогтмол инженерийн баг, хамгааллын баг, хөндлөнгийн үнэлгээний багийн хамтаар, болон ганцаараа биечлэн 21 барилгын ажилд нийт 290 удаа хийж, илэрсэн зөрчлийг гүйцэтгэгч байгууллагаар арилгуулж, хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж ажиллахыг тогтмол шаардаж ажилласан

Барилга угсралтын хийгдэж дууссан ажлууд дээр техникийн болон улсын комиссын гишүүнээр ажиллаж байгаль орчны холбогдолтой дутуу хийгдсэн ажлын жагсаалт гарган гүйцээлгэж хийлгэсэн. ТХН-ийн өгсөн үүрэн даалгаврыг биелэлтээр гүйцэтгэгч нарын гүйцэтгэлийг хянаж, баталгаажуулсан.

Төслийн 1 болон 2 дугаар үе шатны барилга угсралтын трассын дагуу явж нөлөөлөлд өртөж шинээр нүүсэн айлуудыг тодорхойлж, талбай дээрх хог хаягдал цэвэрлэх, жорлон ариутгаж битүүлэх ажил удаашралтай хийгдэж байсныг эрчимжүүлж талбайн цэвэрлэгээний ажил дээр хяналт тавьсан. ухсан нүхнүүдийг битүүлүүлж, ажил гүйцэтгэж байгаа ил задгай талбай дээр хамгааллын тууз тэмдэг тэмдэглэгээ тавиулж ажиллаа.

Сэлбэ, Баянхошуу дэд төвийн 2021 оны Байгаль орчны хяналтын жилийн тайланг АХБ-ны шаардлагад нийцүүлэн бэлтгэж, АХБ-аар хянуулахаар хүргүүлсэн.

Төслийн 1-р үе шатны Байгаль орчны хөндлөнгийн үнэлгээний зөвлөх багын боловсруулсан 2020 оны хөндлөнгийн мониторингийн жилийн тайлантай танилцаж санал шүүмж өгсөн. Засаж сайжруулсан тайланг АХБ-руу хүргүүлж АХБ-ны вэб сайт дээр байршуулсан.

Төслийн 1-р үе шатны Байгаль орчны хөндлөнгийн үнэлгээний зөвлөх багын боловсруулсан 2021 оны хөндлөнгийн мониторингийн жилийн тайлантай танилцаж санал шүүмж өгсөн. Засаж сайжруулсан тайланг АХБ-руу хянуулахаар хүргүүлсэн.

Төслийн 1 дүгээр үе шатны Сэлбэ, Баянхошуу дэд төвийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангуудыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсруулж, НБОГ-аар 2 тайланг дүгнүүлж, батлуулсан

Нийгэм болон жендэрийн үйл ажиллагаа

Нийгэм, жендэрийн үйл ажиллагаа

2021 онд төслийн нэгдүгээр үе шатны Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд нийгэм болон жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд 54 удаагийн иргэдийн уулзалт зохион байгуулж, иргэдэд төслийн явцын мэдээлэл, бүлэг зохион байгуулах, блокийн хөгжил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ /ЖДҮҮ/-г хөгжүүлэх үйл ажиллагаа, хот төлөвлөлт, нийгмийн барилга байгууламжийн үр ашиг, ашиглалт, иргэдийг чадваржуулах төсөл хөтөлбөрүүд гэх мэт шаардлагатай цогц мэдээллүүдийг хүргэв. Иргэдийн уулзалтанд нийт 667 хүн оролцсоноос 66.1% нь эмэгтэй байлаа.



Зураг 1: Төслийн нэгдүгээр үе шатны иргэдийн уулзалт

2. Цар тахлын онцгой нөхцөл байдлаас шалтгаалж иргэдийн уулзалт хийх боломжгүйн учраас Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн авто зам, инженерийн шугам сүлжээ, үерийн хамгаалалтын суваг, тохижилтын ажлын дагуух айл, өрхүүдэд төслийн ажлын явцын мэдээлэл болон аюулгүй байдлын зааварчилгааг бэлтгэн, нийт 240 өрхөд хүргэв.



Зураг 2: Баянхошуу дэд төвийн өрхүүдээр явж, мэдээлэл хүргэв

3. Мөн суурьшлын бүсэд авто зам баригдсантай холбогдуулан иргэдийг зам тээврийн осол, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагаар Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд тухайн хорордын иргэдтэй хамтран 4 долоо хоногийн турш замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллав. Хяналт шалгалт хийж буй иргэдийг тухайн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдтэй хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтад хамруулж, дэд төвүүдэд баригдсан авто замуудад олон нийтээр удирдуулсан хяналтыг хийх сургалт зохион байгуулж, хяналтын төлөвлөгөө гарган ажилласан. Үүнд, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтыг хийхэд нийт 55 (11 эрэгтэй, 44 эмэгтэй) иргэн идэвхитэй оролцов. Хяналтын явцад тэд дараах зөрчлүүд ажиглагдсан байна:

- Хүүхдүүд зам дээр тоглох, машин замаар дугуйтай зорчих
- Сургуулийн өмнөх насны болон бага ангийн хүүхдүүд томчуудын хараа хяналтгүй зам хөндлөн гарах
- Явган хүний гарцаар гарахгүй байх
- Өргөн замд тээврийн хэрэгсэл хурдтай явах

Иймд цаашид учирч болох эрсдэлүүдийг бууруулахын тулд замын ойролцоо амьдардаг 157 (үүнээс 74 эмэгтэй) иргэнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийг хүргэж ажиллав.



Зураг 3: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт, хяналтын баг

4. 2022 м² талбайтай, 472 м² задгай талбай бүхий Сэлбэ бизнес инкубатор төвийн барилгын ажлыг дуусгаж, 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр албан ёсоор нээж Нийслэлийн ЖДҮҮ-г дэмжих төвд хүлээлгэн өглөө. Нээлтийн арга хэмжээнд нийслэл, дүүрэг, хорооны төлөөллүүд, Азийн хөгжлийн банкны төслийн удирдлагууд, хэвлэл мэдээллийнхэн, НЗДТГ-ын төлөөллүүд оролцов. 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар Сэлбэ бизнес инкубатор төвд иргэдийн мэдээллийн төв, Нийслэлийн ЖДҮҮ-г дэмжих төв, Чингэлтэй дүүргийн газар зохион байгуулалтын алба үйл ажиллагаа явуулж, нийт 38 (20 эмэгтэй) хүн ажиллаж байна. Бизнес инкубатор төв нээгдсэнээс хойш нийт 1760 гаруй иргэн үйл ажиллагаа явуулж буй газруудаас үйлчилгээ авсан байна.



Зураг 4: Сэлбэ дэд төвийн бизнес инкубатор төвийн нээлт

5. Баянхошуу дэд төвийн бизнес инкубатор төвд 2021 онд иргэдийн мэдээллийн төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Баянхошуу салбар, Азийн Сангийн санхүүжилттэй Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих инкубатор төв болон дэд төвийн ЖДҮҮ эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 56 (37 эмэгтэй) хүн ажиллаж байна:
 - Нэг цэгийн үйлчилгээний газар – 18 ажилтан
 - Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв – 16 ажилтан
 - Бизнесийн үйл ажиллагаа – 21 бизнес эрхлэгч
 - Иргэдийн мэдээллийн төв – 1 ажилтан

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Баянхошуу салбараас иргэд төрийн 198 төрлийн үйлчилгээг авч байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар Баянхошуу салбар нийт 86,993 үйлчилгээг иргэдэд хүргэсэн байна. Үүнээс 78,660 төрийн үйлчилгээ, 8,333 хувийн хэвшлийн үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн байна. Мөн тус бизнес инкубатор төвд хотын дахин төлөвлөлт, иргэдийн оролцоо, төслийн явц танилцуулах иргэдийн уулзалт, нийгмийн чиглэлийн (хувь хүний хөгжил) сургалтууд, лекц, эвент, өдөрлөгүүд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө, гарааны бизнес бойжуулах зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна. Иргэдийн мэдээллийн төвөөр 2021 онд нийт 558 иргэн үйлчлүүлж, дахин төлөвлөлт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх үйл ажиллагаа, бизнес инкубатор төвийн үйл ажиллагааны тухай мэдээлэл авлаа.

6. Иргэдийн мэдээллийн төвөөр дамжуулан Монголын Урлагийн Зөвлөл ТББ-тай хамтран “Миний-Гэр” хөтөлбөрийн хүрээнд номын сангийн үйлчилгээг ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчид болон цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхэд багачуудад үйлчилж байна. Миний гэр хүүхдийн номын сан нь нийт 148 гишүүнтэй бөгөөд үүний 63 эрэгтэй 85 эмэгтэй болсон байна. Сэлбэ дэд төвийн 240 хүүхдийн багтаамжтай Чингэлтэй дүүргийн 280-р цэцэрлэгт 2020-2021 оны хичээлийн жилд 38 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, Ковид-19 цар тахлын үеийн түр журмын дагуу халдвар хамгааллын дэглэмээ баримтлан 4-5 насны 133 хүүхэдтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бол Баянхошуу дэд төвийн 261-р цэцэрлэг 41 ажилтан, 215 хүүхэдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 5: Сэлбэ дэд төв, 280-р цэцэрлэгийн үйл ажиллагаа

7. Төслийн нэгдүгээр үе шатны бүтээн байгуулалт, нийгмийн барилга байгууламж, зам, дэд бүтцийн ажлуудын үр нөлөөг үнэлэх зорилгоор үр дүнгийн үнэлгээ, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг “Тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-тай хамтран 2021 оны 12 дугаар сард хийв. Баянхошуу, Сэлбэ дэд төвийн нийт 682 өрхөөс судалгаа авч, 5 удаагийн бүлгийн ярилцлага хийж судалгааны мэдээллийг цуглуулж, анализ хийхэд бэлэн болгов. Мөн ус, дулаан, бохирын шугамд холбогдсон 40 аж ахуй нэгжээс судалгаа аваад байна.
8. АХБ болон Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж буй “Ур чадварыг хөгжүүлэх” олон улсын туршилтын төслийг 3 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд 3 жилийн хугацаанд нийт 265 (22 эмэгтэй) иргэн барилгын чиглэлийн 7 мэргэжлээр (гагнуур, сантехник ба халаалт, агааржуулалт, бетон хийц, цахилгаан, дотоод засал, мужаан, тоосго өрөх) мэргэжлийн ур чадварын үнэлгээнд хамрагдаж, 198 (21 эмэгтэй) иргэн мэргэжлийн сертификат гардан авсан. Мэргэжлийн үнэмлэх авсан 2 иргэнийг гүйцэтгэгч компанид ажилд зуучилсан байна. Мөн гүйцэтгэгч компанийн 55 (12 эмэгтэй) инженер техникийн ажилтанг үйлдвэрлэлийн дадлагажуулагчаар бэлтгэв. Сургагдсан дадлагажуулагчид цаашдаа барилга дээр ажиллаж буй иргэд болон дадлагажигч оюутнуудыг сургаж, заавар зөвлөгөө өгч ажиллах юм.



Зураг 6: Ганцаарчилсан зөвлөгөө, ажлын байран дахь дадлагын үйл ажиллагаа

Барилгын политехникийн коллежтой хамтран “Эмэгтэйчүүд барилгын салбарт” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, Баянхошуу дэд төвийн 3 сургуулийн ахлах ангийн 28 охид оролцож, сургалтын дадлагын танхимуудад мэргэжлийн багш нарын удирдлага зааварчилгааны дагуу дадлага хийж, барилгын мэргэжилүүдтэй танилцав. Түүнчлэн өдөрлөгийн төгсгөлд охид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдлаа.

Мөн төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг ажил идэвхтэй хайж буй иргэд болон ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн хүүхдүүдэд зохион байгуулав. Үүний үр дүнд 1168 сурагч (54% эмэгтэй), 535 эцэг эх (60% эмэгтэй), 19 багш (52% эмэгтэй) цахимаар

бүлгийн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдав. Зөвлөгөөний үеэр сурагчид мэргэжилтэй болох боломж, мэргэжлээ сонгохдоо гаргадаг нийтлэг алдаанаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авсан бол эцэг эхчүүд ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын мэргэжил сонголтонд эцэг эхийн нөлөөлөл, мэргэжил сонгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар мэдээлэл авлаа. Ганцаарчилсан зөвлөгөөг Баянхошуу, Дамбадаржаа дэд төвийн 47 (34 охин) ахлах ангийн сурагчид, 34 (13 эмэгтэй) ажил идэвхтэй хайж буй иргэд байв.

9. Азийн Сангийн санхүүжилттэй “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих инкубатор төв” 2020 оны 3-р сараас эхлэн Баянхошуу бизнес инкубатор төвд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2021 оны 12-р сарын байдлаар нийт 1734 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд бизнесийн зээл авах тухай, барилцагчийн үйлчилгээ ба харилцагчийн туршлага, цахим маркетинг, бизнесийн ёс зүй, бизнес төлөвлөгөө боловсруулах, бизнесийн баг зохион байгуулах, бизнес модель, оюуны өмчийн тухай зэрэг сургалтуудыг зохион байгууллаа. Нийт сургалтад хамрагдсан иргэдийн 95% нь эмэгтэйчүүд байв.
10. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн зорилтот бүлгийн өрхүүдийн амьжиргааг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Өрхийн амьжиргаа дэмжих техникийн туслалцааны төсөл”-ийн хүрээнд 2021 онд төслийн 1-р үе шатны нөлөөлөлд өртсөн 13 өрхөд дэмжлэг үзүүлсэн бөгөөд үүнд 11 иргэнийг мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулж, 4 иргэнд тоног төхөөрөмжийг дэмжлэг үзүүллээ.

Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа

Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төвтэй хамтран ЖДҮҮ эрхлэгчдийг чадваржуулах хүрээнд санхүүгийн удирдлага, төлөвлөлт, санхүүгийн тайлагнал, татвар, хууль эрх зүйн орчин, борлуулалт маркетинг, мэдээллийн технологийг ашиглан бизнесээ өргөжүүлэх, зардлаа хэмнэх боломж, харилцааны ур чадвар, бизнес төлөвлөгөө боловсруулах, зээл хүсэх материал бүрдүүлэх, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа, хөдөлмөр халамж үйлчилгээний газрын зээл, хөтөлбөрт хамрагдах зэрэг сэдвээр нийт 42 удаагийн сургалт зохион байгуулж, ЖДҮҮ эрхлэгч 336 иргэн, ААН сургалтад хамрагдсан байгаа бөгөөд үүний 228 буюу 67.9% нь эмэгтэй оролцогчид байна. Үүнээс Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төв 40 сургалтыг зохион байгуулж 320 ЖДҮҮ эрхлэгчдэд хамруулсан байна. Онлайнаар сургалтын материал, зурагт хуудас бэлтгэн цаасаар болон олон нийтийн сүлжээ ашиглан хүргэх зорилгоор 34 онлайн сургалтын материал, мэдлэг олгох зурагт хуудас зэргийг бэлтгэж 1500 гаруй ЖДҮҮ эрхлэгч нарт хүргэв. Мөн Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төвийн үйл ажиллагааны хүрээнд Сэлбэ бизнес инкубатор төвийг түшиглэн 765 ЖДҮҮ эрхлэгчдэд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна. Үүний 62% нь эмэгтэй байсан.



Зураг 7: ЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө

Дэд төвийн иргэд, ААН-ийн түгээмэл эрхэлдэг бизнесийн чиглэлүүдэд зориулсан загвар бизнес төлөвлөгөөг боловсруулан 113 ЖДҮҮ эрхлэгчид илгээгээд байна. Ингэснээр ЖДҮҮ эрхлэгчид загвар төсөл дээр тулгуурлан богино хугацаанд өөрийн бизнес төлөвлөгөөг

боловсруулах, бизнес төлөвлөгөө боловсруулах туршлага, чадавх суух боломж нэмэгдэж байгаа юм.

1. Ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 11-р сард “Ажилд зуучлах нээлттэй өдөрлөг”-ийг Германы Олон улсын хамтын ажиллагааны Нийгэмлэг, Зангиа портал ХХК болон гэрээт гүйцэтгэгч компаниудтай хамтран зохион байгуулав. Арга хэмжээнд нийт 23 ажил олгогч байгууллага, сургалтын байгууллагууд оролцож, иргэдийг ажилд зуучлах, ажил хайгчаар бүртгэх, мэргэшүүлэх сургалтад бүртгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд Сэлбэ дэд төвийн нийт 137 ажил хайгч иргэд оролцсон бөгөөд үүний 49 /35.8%/ эрэгтэй, 88 /64.2%/ нь эмэгтэй оролцогчид байна. Уг арга хэмжээний үр дүнд 55 хүн ажлын байраар хангагдсан байна.
2. Сэлбэ, Баянхошуу бизнес инкубатор төвүүдийг түшиглэн Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Ковид-19 цар тахлын үед Улаанбаатар хотын гэр хорооллын бичил, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих (45007-012)” техникийн туслалцааны төслийг 2021 оны 5-р сараас эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд бичил болон ЖДҮҮ эрхлэгчдийг чадавхижуулах хадгаламжийн бүлэг, аж ахуйн нэгжийн бүртгэл, санхүүгийн бүртгэл, зээлийн өргөдөл, бизнес төсөл бичих, цахим шилжилт, хууль эрх зүй, санхүүгийн менежментийн чиглэлээр Баянхошуу, Сэлбэ дэд төвийн нийт 854 оролцогчдод 77 удаагийн сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулсан байна. Оршин суугчдыг чадавхижуулж, бизнесийн зөвлөгөө үзүүлэх менторуудыг бэлтгэх сургалтад 42 оролцогчийг сургаж, бэлтгэв. Мөн амжилттай ажиллаж буй хоршооны үйл ажиллагааг газар дээр нь очиж танилцуулах зэрэг арга хэмжээнд нийт 20 гаруй хүнийг хамруулав. Төслийн хүрээнд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх тухай нээлттэй зарыг дэд төвүүдийн бизнес эрхлэгчдийн дунд зарлаж, сонгон шалгаруулалтыг хийж, 12-р сарын 31-ний байдлаар 33 иргэн, ААН-ийг сонгон шалгаруулж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлээд байна.
3. ЖДҮҮ эрхлэгчдийн мэдээллийн сан бүрдүүлэх хүрээнд дэд төв тус бүрт төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бичил болон ЖДҮҮ эрхлэгчдийн талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулж, шаардлагатай мэдээ мэдээлэл, зарыг хүргэх, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэхээр өгөгдлийн санг үүсгээд байна. Нийт Баянхошуу дэд төвийн Дэд төвийн бичиг болон ЖДҮҮ эрхлэгчдийн нөхцөл байдал, хэрэгцээ тодорхойлох судалгааг уг хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 6-р сард хийсэн бөгөөд судалгааны тайланг үндэслэн сургалтын сэдвийг тодорхойлох, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх цар хүрээг тодорхойлсон. Нийт судалгаанд 276 бизнес эрхлэгч хамрагдсан бөгөөд судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 66.7% нь эмэгтэйчүүд байна. Мөн Баянхошуу дэд төвийн бизнес эрхлэгч 307 иргэн, ААН болон Сэлбэ дэд төвийн 403 иргэн, ААН-ийн үйл ажиллагааны чиглэл, хаяг, утас зэрэг мэдээллийг бүрдүүлсэн. Дэд төв тус бүрийн Бизнес эрхлэгчдэд зориулсан мэдээлэл, сургалтын материал түгээх, харилцан туршлага солилцох, хамтрах, бараа бүтээгдэхүүнээ сурталчлах зориулалт бүхий Фэйсбүүк группүүдыг үүсгэсэн ба одоогийн байдлаар Баянхршуу дэд төвийн групп 1184, Сэлбэ дэд төвийн бизнес эрхлэгчдийн групп 939 гишүүнтэй байна.
4. Сэлбэ, Баянхошуу дэд төвд баригдсан Бизнес инкубатор сургалтын төвүүдийн үйл ажиллагаа үргэлжилж байна.

Баянхошуу бизнес инкубатор төвд 2021 оны эцсийн байдлаар 10 ЖДҮҮ эрхлэгч үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 21 хүн ажлын байраар хангагдан ажиллаж байна. Тус 10 ЖДҮҮ эрхлэгчийн 9 нь эмэгтэй бизнес эрхлэгчийн тэргүүлсэн бизнес бөгөөд 18 эмэгтэй ажиллаж байна. Тус төвийн ашиглагч байгууллагаар Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар ажиллаж байгаа бөгөөд 2021 оны хувьд 8 удаагийн арга хэмжээ, сургалт зохион байгуулсан байна.



Зураг 8: Бизнес инкубатор төв дэх сургалтын үй ажиллагаа

Сэлбэ бизнес инкубатор төвд Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв болон Чингэлтэй дүүргийн газар зохион байгуулалтын алба үйл ажиллагаагаа явуулж байна. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв болгон үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэ хүрээнд:

1. ЖДҮҮ-ний нэг цэгийн үйлчилгээ;
2. Нэгдсэн сургалт, бойжуулалтын хөтөлбөр;
3. ЖДҮҮ эрхлэгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх уулзалт арга хэмжээ;
4. Төр хувийн хэвшлийн түншлэлээр үндэсний томоохон ААН-тэй хамтран старт-ап бизнесийг хөгжүүлэх;
5. ЖДҮҮ эрхлэгчдэд чиглэсэн санхүү, техникийн туслалцааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулагдаж, давхардсан тоогоор Улаанбаатар хотын нийт 9 дүүргийн 1200 гаруй иргэн, аж ахуйн нэгж нэг цонхноос зөвлөгөө мэдээлэл авч, 20 гаруй компани шинээр байгуулагдаж, 130 гаруй ажлын байрны захиалгыг хүлээн авч, ажил хайж буй иргэдэд танилцуулсан байна.

Олон нийтийн оролцооны үйл ажиллагаа

2021 онд Баянхошуу, Сэлбэ дэд төвийн иргэдэд төслийн явцын мэдээлэл хүргэх, санал солилцох, иргэдийн оролцоог хангах сургалт, уулзалтуудыг халдвар хамгааллын дэглэм, зааварчилгааг баримтлан үе шаттайгаар зохион байгууллаа. Үүнд:

1. Баянхошуу болон Сэлбэ дэд төвийн иргэдэд нийт 54 уулзалт, сургалтыг зохион байгуулж 667 хүнд хүрч ажиллаа. Үүний 66.1% эмэгтэй оролцогчид байна. Үүнээс дурдвал нийт 4 удаагийн төслийн явцын танилцуулга уулзалтыг Сэлбэ, Баянхошуу дэд төвийн иргэдэд зохион байгуулсан бөгөөд нийт 215 хүн уг уулзалтуудад хамрагдав. Үүний 69.3% эмэгтэй оролцогчид байна. Уулзалтын үеэр инженерийн байгууламжуудын бүтээн байгуулалтын явцын мэдээллүүд, төсөл хамтын ажиллагаа, өргөдөл гомдлын механизм танилцуулагдснаас гадна замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулав.



Зураг 9: Төслийн явцын мэдээлэл өгөх уулзалт

2. Иргэдийн бүлгүүдийг идэвхжүүлэх, шинээр бүлэг байгуулах зорилгоор нийт 35 удаагийн бүлгийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 342 хүн хамрагдав. Үүний үр дүнд шинээр 162 гишүүдтэй 11 хуримтлалын бүлэг байгуулагдснаас Баянхошуу дэд төвд 97 гишүүдтэй 4 бүлэг, Сэлбэ дэд төв 65 гишүүдтэй 7 бүлэг байгуулагдаад байна.
3. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд байгуулагдсан Оршин Суугчдын Зөвлөл, ТББ, Бизнесийн Зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 6 удаагийн зөвлөлдөх уулзалтыг 41 оролцогчтойгоор зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд ОСЗ, БЗ-ийн гишүүд үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд анхааран, төлөвлөгөөгөө шинэчлэн ажиллаж эхлэв.



Зураг 10: ОСЗ, БЗ, ТББ-ын гишүүдийн уулзалтууд

4. Ковид-19 цар тахлын үеийн хөл хорионы улмаас олон нийтийн уулзалт, арга хэмжээ хийгдэж чадахгүйд хүрсэн. Тиймээс үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс цахимаар мэдээлэл түгээж, цахим уулзалтуудыг хийж ажиллав. 2021 оны эцсийн байдлаар Баянхошуу болон Сэлбэ дэд төвд нийт 4374 гишүүдтэй 20 Фейсбүүк групп байгаа бөгөөд эдгээр группуудээр дамжуулж төслийн танилцуулга, олон талын мэдээ мэдээллийг нийтлэх, уулзалт сургалтуудын зар түгээх, санал солилцох зэргээр ажилласан.
5. Дэд төвийн иргэдэд төслийн барилга бүтээн байгуулалтын ажлын мэдээлэл, аюулгүй байдлын зөвлөмж, замын аюулгүй байдал, мэдээллийг хангах үүднээс нийт 240 өрхөөр орж мэдээлэл хүргэлээ.

Өргөдөл гомдлыг хүлээж авах шийдвэрлэх үйл ажиллагаа

ТХН нь гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэхдээ Нийслэлийн Засаг Даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж ажиллаж байна.

Нийслэлийн Нутгийн Захиргааны Байгууллагуудын нэгдсэн систем – UB ERP системд өргөдөл, гомдол, санал хүсэлтүүдийг бүртгэж, хянадаг.

Төслийн барилгын ажлууд хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2018-2021 он хүртэл нийт 382 өргөдөл гомдол ирсэн байна. 2018 онд 153, 2019 онд 39, 2020 онд 264, 2021 онд 105 нт ирсэн байна. Нийт 283 өргөдөл гомдлыг иргэний талд шийдвэрлэсэн.

Нийт ирсэн өргөдөл гомдлыг агуулгаар ангилбал 29% нь хөрөнгийн үнэлгээ, нөхөн олговрын тухай, 18% нь барилга угсралтын ажилтай холбоотой, 12% нь хүрээлэн буй орчны нөхөн сэргээлттэй холбоотой, 8.5% нь газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой байна.

2021 онд 105 өргөдөл гомдол ирснээс 96.2%-ыг бүрэн шийдвэрлээд байна. Үүнээс 60 өргөдөл гомдлыг иргэний талд шийдвэрлээд байна.

ХӨТӨЛБӨРИЙН ХОЁР ДУГААР ҮЕ ШАТ – ДАМБАДАРЖАА, ДЭНЖИЙН МЯНГА ДЭД ТӨВ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд (i) хотын хойд хэсэгт байрладаг Дамбадаржаа, Дэнжийн дэд төвүүдэд хотын дэд бүтцийг шинэчлэх өргөтгөх, Баянхошуу, Сэлбэ дэд төвд нэмэлт хөрөнгө оруулалт хийх, (ii) нийгэм эдийн засгийн барилга байгууламж барих, (iii) чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн 1-үе шатны дэд төвүүдээс гадна хөтөлбөрийн 2-р үе шатнаас нийт 55,331 хүн (13,702 өрх) үр шим хүртэнэ. Үүнээс Дамбадаржаад буюу Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 109,82 га талбайд 18,349 хүн 1725 өрх, Дэнжийн мянга буюу Чингэлтэй дүүргийн 10-13 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 62.27 га талбайд 36,982 хүн, 8840 өрх амьдарч байна.

Үе шат 2-ын зээлийн хэлэлцээрийг 2017 оны 12 сарын 6-нд батлуулсан.

Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

(сая ам.доллар)

Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь
АХБ-ны санхүүжилт		
МОН-3025 (COL)	29.24	24.14
МОН-3026 (OCR)	37.11	30.63
Дэд дүн	66.35	54.77
НЗДТГ-ын төсөв	35.15	29.02
ЕХОБ-ны санхүүжилт FI'83097	19.64	16.21
Нийт	121.14	100

(сая ам.доллар)

№	Үндсэн үйл ажиллагаа	Төлөвлөсөн
А. Суурь зардал		103.46
I	<i>Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх</i>	<i>80.33</i>
1.1	Автозам сайжруулах	30.69
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	16.74
1.3	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	32.90
II	<i>Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх</i>	<i>18.84</i>
III	<i>Байгууллагыг чадавхижуулах</i>	<i>4.29</i>
Б. Магадлашгүй ажил		11.06
В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж		6.62
Нийт дүн		121.14

Хөтөлбөрийн 2-р Үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд Дамбадаржаа, Дэнжийн мянга төвүүдийн бүтээн байгуулалтыг хийх бөгөөд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нэмэлт бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ 2-үе шатны хэрэгжилтийн явц 33.25% байна.

Үйл ажиллагаа	Бодит явц
ГЧНШ	50.42%
Төлөвлөлт	67.14%
Хэрэгжүүлэлт	57.99%
ХАА	44.98%
Барилгын ажил	43.43%
Зөвлөх үйлчилгээ	52.13%
Бараа	95.10%
Барилга угсралт	20.94%
Зураг төсөл боловсруулалт	70.19%
Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	25.03%
Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд	10.07%
Зөвлөх үйлчилгээ	37.43%
Нийт	33.25%

Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд Дэд төвүүдийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн тоймыг дараах хүснэгтээс харна уу

Барилга байгууламж	Баянхошуу дэд төв	Дамбадаржаа дэд төв	Дэнжийн мянга дэд төв
Автозам	-	3.3 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан.	1.1 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 90%
Цахилгааны шугам сүлжээ	-	12 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	20 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.
Дулаан хангамжийн шугам сүлжээ	4.9 км км хийгдсэн	5.6 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	8.2 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 80%
Ус хангамжийн шугам сүлжээ	-	3.5 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	8.2 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 90%
Ариутгах татуургын шугам сүлжээ	-	4.5 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	5.7 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 90%
Үерийн хамгаалалтын далан суваг	-	1.5 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөлд 2020 онд магадлал хийгдсэн. -100%	3.5 км төлөвлөсөн Нарийвчилсан зураг төслийг магадлалаар батлуулсан бөгөөд ХАА үйл ажиллагаа эхэлж байна

Цэцэрлэгт хүрээлэн	Барилгын ажлын явц – 54%	-	-
Дулааны станц /Эх үүсвэр/	-	63МВт дулааны станцын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил 83%	-
Мэдээлэл холбооны үйлчилгээний төв	-	Зураг төслийн боловсруулалтын явц - 50%	Зураг төслийн боловсруулалтын явц - 50%
Олон нийтийн хөгжлийн төв	Барилгын ажлын явц – 13%	Зураг төслийн боловсруулалтын явц - 90%	-
Цэцэрлэг	Барилгын ажлын явц – 10%	150 хүүхдийн цэцэрлэг Нарийвчилсан зураг төслийг магадлалаар батлуулсан бөгөөд ХАА үйл ажиллагаа эхэлж байна.	240 хүүхдийн цэцэрлэг Зураг төслийн боловсруулалтын явц – 21%
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр	ХАА-ын үйл ажиллагааг дахин эхлүүлсэн. ХАА-ны явц -67.5%-тай байна	-	-
Нэгдүгээр зэрэглэлийн аврах, гал түймэр унтраах 29 дүгээр ангийн барилга	ХАА-ын үйл ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд явц нь 19% байна.	-	-
Спорт цогцолбор	Гэрээг байгуулсан бөгөөд барилгын ажлын улирал дууссан тул барилгын ажлыг эхлүүлээгүй байна	Газар чөлөөлөлт хийгдээгүйн улмаас зураг төслийн ажил зогссон, хүлээлтийн байдалтай байна.	-

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

2021.09.16-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 30 барилгын ажил, 6 бараа, 7 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 13 барилгын ажил, 3 бараа, 5 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна.



Одоогийн байдлаар дараах ажлуудын худалдан авалтын үйл ажиллагааг эхлүүлээд байна.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
---	-----------	----------------------

1	Сонгинохайрхан дүүргийн 40-р хороо, Гал унтраах аврах 29 дүгээр ангийн барилга угсралтын ажил	12 сарын 24-нд тендер зарласан.
2	Дамбадаржаа дэд төвд баригдах үерийн хамгаалалтын далан, сувгийн ажил	12 сарын 24-нд тендер зарласан.

Худалдан авалтын үйл ажиллагааны явц 45%-тай байна.

Энэхүү үе шатны хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтийн мэдээллийг **Хавсралт 4-т** үзүүлэв.

БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦ

Хөтөлбөрийн 2 дугаар үе шатны хүрээнд нийт 11 барилгын ажлыг гүйцэтгэж байна.

Энэхүү үе шатны хүрээнд АХБ-ны санхүүжилтээр 1, АХБ болон Нийслэлийн хамтарсан санхүүжилтээр 6, ЕХОБ-ны санхүүжилтээр 4 барилгын ажлыг гүйцэтгэн ажиллаж байгаагаас нийт 5 барилгын ажлын улсын комиссыг ажиллуулан зарим барилгын ажлуудыг холбогдох ашиглагч байгууллагад хүргүүлээд байна.

№	Барилгын ажлын нэр	Улсын комисс ажилласан огноо	Хөрөнгөд бүртгэсэн огноо/ захирамж дугаар
АХБ-ны санхүүжилт			
1	GWD11: Хөрсний ус зайлуулах шугам - Үе шат 1	10/12/2020 № ИС-63/2020	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол хүлээгдэж байна
2	GWD14: Хөрсний ус зайлуулах шугам - Үе шат 2	10/30/2020 № ИС-89/2020	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол хүлээгдэж байна
ЕХОБ-ны санхүүжилт			
3	BHF06B: Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 1ли магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	02/08/2021 № ИС-028/2021	8/20/2020-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
4	WSC16B: Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	08/05/2021 10/07/2021	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
5	HSSC-B: Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил	10/07/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.

Дээрх хүлээлгэн өгсөн барилгуудын ажлаас дараах үр дүн гарч байна.

- Сэлбэ дэд төвийн 4.1 км хөрсний ус зайлуулах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэснээр хөрсний усны түвшин доошилж тухайн хэсэгт Хөтөлбөрийн 1-р үе шатны хүрээнд хийгдэж байсан инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан.
- Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насос станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган

нийлүүлэлт, угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад өгснөөр дараах үр дүн гараад байна. Үүнд:

- Дулааны 11и магистраль шугам хоолойг өргөтгөж, шинэчлэх ажлыг хийснээр Ханын материал, Баянхошуу орчмын барилга байгууламж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох нөхцөл бүрдэж, шинээр дулааны магистраль шугам Баянхошуу дэд төв рүү татах боломж үүссэн.

Барилгын ажлын дэлгэрэнгүй мэдээллийг дараах хэсэг хөтөлбөрийн 2 дугаар үе шатны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр дараах байдалтай байна.

БҮРЭЛДЭХҮҮН 1. АВТО ЗАМ БОЛОН ХОТЫН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Тайлангийн хугацаанд хөтөлбөрийн I үе шатанд боловсруулагдсан барилга угсралтын ажлуудын нарийвчилсан зураг төслийн дагуу 6 барилгын ажил гүйцэтгэгдэж дууссан байна.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 1 барилгын ажил үргэлжлэн хийгдэхээр өвлийн бэлтгэл ажлыг хийж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц
АХБ-ны санхүүжилт				
1	GWD 14	Сэлбийн хөрсний ус зайлуулах 2,2 км шугамын ажил	Ф800мм ус шүүрүүлэх бетон хоолой 1799м, Ф1000 бетон хоолой 2891м, Ф1500мм-н угсармал төмөр бетон худаг 35ширхэг	100%
2	GWD 11	Сэлбийн хөрсний ус зайлуулах 1,3 км шугамын ажил	Ф800мм ус шүүрүүлэх бетон хоолой 1305м	100%
3	BHF06B	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насос станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	Өргөлтийн насос станц Ус дулаан дамжуулах төв Дулааны шугам, 3.05км 2*400кВА Дизель генератор 2*160кВА хаалттай дэд өртөө 2*250кВА хаалттай дэд өртөө	100%
ЕХОБ-ны санхүүжилт				
4	HSSC-A	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	66ш сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	100%
5	HSSC-B	2-р хэлхээний дулаан хангамж, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил	СБД-н 14-р хороо, Өрхийн эмнэлгийн дулаан хангамжийн системд холбох - 500м 35-р сургуулийг дулаан хангамжийн системд холбох - 1315м 51-р цэцэрлэгийг дулаан хангамжийн системд холбох-615м Түр суурьшуулах 50 айлын орон сууцыг дулаан хангамжийн системд холбох-200м 280-р цэцэрлэгийг дулаан хангамжийн системд холбох-900м	100%

			Сэлбийн бизнес инкубатор, МСҮТ-ийг дулаан хангамжийн системд холбох-1085м Дулааны узель угсрах-8ш	
6	WSC16B	Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	Ус дулаан дамжуулах төв Дулааны шугам, 0.594км Цэвэр усны шугам, 0.594км Бохир усны шугам, 2,3 км Хаалттай дэд өртөө Гадна цахилгаан	100%
7	USF	Морингийн даваа орчмын шинэ суурьшлийн бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	Гадна цэвэр усны шугам, 5.3км Усны сангийн барилга, 1000м3 Усан сангийн харуулын байрны барилга Гадна бохир усны шугам, 2.7км Насос станцын барилга, харуулын байр, 2ш Гадна цахилгаан хангамж, 12.8км Хуваарилах байгууламж Гадна холбооны ажил, 4км	44%

Хөтөлбөрийн үе шат II-ийн хүрээнд баригдах барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг боловсруулалтын явц дараах байдалтай байна. Үүнд:

№	Барилгын ажлын нэр	Зураг төсөл боловсруулалтын явц
1	Дамбадаржаа дэд төвийн үерийн хамгаалалтын суваг	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
2	Дамбадаржаа дэд төвийн авто зам болон инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
3	Дамбадаржаа дэд төвийн цахилгаан холбооны ажил	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
4	Дамбадаржаа дэд төвийн дулааны станц	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
5	Дэнжийн мянга дэд төвийн үерийн хамгаалалтын суваг	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
6	Дэнжийн мянга дэд төвийн цахилгаан холбооны ажил	80%
7	Дэнжийн мянга дэд төвийн авто зам болон инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
8	Дамбадаржаа дэд төвийн дулааны станц	10%

БҮРЭЛДЭХҮҮН 2. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 1 барилгын ажил үргэлжлэн хийгдэхээр өвлийн бэлтгэл ажлыг хийж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Ажлын тоо хэмжээ	Ажлын явц
		АХБ-ны санхүүжилт		

1	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	42%
2	ASKG-BKH	240-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхошуу дэд төв/	11%
3	DDPK-BKH	2га талбайд Цэцэрлэгт хүрээлэн /Баянхошуу дэд төв /	60%
4	DDCD-BKH	Олон Нийтийн Хөгжлийн төв /Баянхошуу дэд төв/	13%

Хөтөлбөрийн үе шат II-ийн хүрээнд баригдах барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг боловсруулалтын явц дараах байдалтай байна. Үүнд:

№	Барилгын ажлын нэр	Зураг төсөл боловсруулалтын явц
1	650 хүний суудалтай Спорт Цогцолбор /Баянхошуу дэд төв/	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
2	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
3	Спорт Цогцолбор /Дамбадаржаа дэд төв/	Газар чөлөөлөлт хийгдээгүйн улмаас зураг төслийн ажил зогссон, хүлээлтийн байдалтай байна. - 21%
4	Олон Нийтийн Хөгжлийн төв /Дамбадаржаа дэд төв/	Газар шийдэгдээгүй учир зураг төсөл боловсруулалтыг хийж эхлээгүй байна.
5	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дамбадаржаа дэд төв/	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
6	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дэнжийн мянга дэд төв/	Газар шийдэгдээгүй учир зураг төсөл боловсруулалтын ажил түр зогссон байна.
7	Гал унтраах ангийн барилга	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан

Дээрх 2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд гүйцэтгэж байгаа барилгын ажлын зургийг **Хавсралт 5-д** хүргүүлэв.

БҮРЭЛДЭХҮҮН 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Энэ бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж барилгын ажлуудтай холбоотой болон хот төлөвлөлт, дэд төвүүдийн хөгжлийг боловсронгуй болгох, дэд төвийн бүтээн байгуулалтын талаарх иргэдийн ойлголтыг төлөвшүүлэх, тэдний оролцоог хангах, дэд бүтцийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх юм.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна

АХБ-НЫ ХАМГААЛЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт 6 төлөвлөгөө, 7 зохистой байдлын тайлан боловсруулж АХБ-аар баталгаажуулахаас 7 зохистой байдлын тайлан боловсруулаад байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон зохистой байдлын тайланг боловсруулахад тухайн сонгосон байршил болон амьдарч буй иргэдтэй зөвлөлдөх уулзалтууд хийх болон нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдээс нийгэм эдийн засгийн судалгаа авах шаардлагатай байдаг. Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн КОВИД-19 цар тахал гарсны улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон тул эдгээр ажлуудыг хийх боломжгүй байдал үүсэж, тодорхойгүй хугацаагаар хойшилж байгаа нь төслийн нийт ажлыг хугацаа хоцроох эрсдэлтэй байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт ажлын явц тайлангийн хугацаанд 60.76%-д хүрсэн байна.

Төслийн зураг төслүүд дуусаж байгаатай холбогдуулан дараах хүснэгтэд заасан нэгж талбарыг чөлөөлөхөөр төлөвлөөд байна.

Дэд төв	Барилга	Нөлөөлөлд өртсөн нэгж талбар			
		Нийт	Бүтэн	Хагас	Газрын эрхгүй
Баянхошуу	240 хүүхдийн цэцэрлэг	1	1		
	Үерийн далан	34	13	18	3
	Дулааны шугам	26	5	16	5
	Автозам	46	31		15
	Цэцэрлэгт хүрээлэн	1	1		
Нийт		108	51	34	23
Дамбадаржаа	150 хүүхдийн цэцэрлэг	15	11		4
	Мэдээлэл холбооны техникийн барилга	2	1		1
	Дулааны станц	50	41		9
	Автозам, инженерийн шугам сүлжээ	203	127	3	73
	Автозам, инженерийн шугам сүлжээ / 2 хэсэг	65	9	46	10
Сэлбэ	OSPF	6		5	1
Нийт		341	189	54	98
Нийт		449	240	88	121

Тайлант хугацаанд дараах хэсгүүдийн газруудыг чөлөөлөн нөхөн олговрыг олгоод байна

Дэд төв	Ажлын нэр	Бүтэн	Хагас	Газрын эрхгүй өрх	НО-ын гэрээ хийсэн	Нийт нөхөн олговрын дүн
2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/863 тоот						
Дамбадаржаа	150 Хүүхдийн цэцэрлэг	11		4	15	996,442,256
	Холбоо мэдээлэл, технологийн техникийн байр	1		1	2	97,464,486
	Дүн	12		5	17	1,093,906,742
	2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/526 тоот					
	Дулааны станц	41		9	50	3,117,632,713
	Автозам, инженерийн барилга байгууламж	122	2	65	189	11,591,804,596
Баянхошуу	Цэцэрлэгт хүрээлэн	1			1	70,608,727
Сэлбэ	OSPF	5		1	6	131,156,637
	Дүн	169	2	75	246	14,911,202,673
Нийт дүн		181	2	80	263	16,005,109,415

Байгаль орчны хамгааллын үйл ажиллагаа

Төслийн 2-р үе шатны Анхдагч байгаль орчны үнэлгээ (АБОҮ/ІЕЕ), Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ/ЕМР) Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвийн батлагдсан зураг төсөл болон төслийн үйл ажиллагаатай уялдуулан шинэчилж, АХБ-руу 2 тайланг хянуулж батлуулахаар хүргүүлсэн.

Төслийн 2 дугаар үе шатны 1)Цайз 2)Морингийн даваа, 3)Баянхошуу&Ханын материал, 4)Амгалан, 5)Налайх, 6)Дамбадаржаа дэд төвийн 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 дугаар журмын дагуу боловсруулж, БОАЖЯ, НБОГ-аар 6 тайланг батлуулсан.

1)Морингийн даваа, 2)Баянхошуу&Ханын материал, 3)Амгалан, 4)Налайх, 5) Цайз, 6) Тээврийн үйлчилгээг сайжруулах, 7)Дамбадаржаа дэд төв, 8) Дамбадаржаа дулааны станц, 9) Дэнжийн мянга дэд төвийн байгаль орчны төлөв байдлын тайланг хянаж, дутуу орхигдсон мэдээллийг гүйцээн оруулж, холбогдох бичиг баримтыг бэлтгэн БОАЖЯ, НБОГ-т хүргүүлж байгаль орчны ерөнхий үнэлгээний 9 дүгнэлтийг авсан.

1)Морингийн даваа, 2)Баянхошуу&Ханын материал, 3)Дамбадаржаа дэд төв, 4) Дамбадаржаа дулааны станц, 5) Дэнжийн мянга дэд төвийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн төсөлтэй танилцаж, санал шүүмж өгсөн. Мөн үнэлгээний тайлангуудыг БОАЖЯ-ны зөвлөлийн хурлаар танилцуулж батлуулсан.

Төслийн 2 дугаар үе шатны байгаль орчны хөндлөнгийн үнэлгээ хийхээр шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж Байгаль орчны хөндлөнгийн мониторингийн эхлэлийн тайланг хянан шүүмж өгч сайжруулан хүлээн авсан.

Төслийн 2-р үе шатны 2021 оны Байгаль орчны хяналтын жилийн тайланг АХБ-ны шаардлагад нийцүүлэн бэлтгэж, АХБ-аар хянуулахаар хүргүүлсэн.

Төслийн 2 дугаар үе шатны 1)Цайз 2)Морингийн даваа, 3)Баянхошуу&Ханын материал, 4)Дамбадаржаа дэд төвийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангуудыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсруулж, НБОГ-аар 4 тайланг дүгнүүлж, батлуулсан

Нийгэм болон жендэрийн үйл ажиллагаа

Төслийн 2-р үе шатны зорилтот орон нутаг олох Дамбадаржаа, Дэнжийн Мянга дэд төвүүдэд дараах үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төслийн тухай мэдээлэл хүргэх 40 удаагийн уулзалт зохион байгуулж, 881 (542 эмэгтэй) иргэдэд төслийн явцын мэдээлэл, төсөл хөтөлбөрийн хамтын ажиллагаа, иргэдийн чадваржуулах хөтөлбөрүүд, олон нийтийн оролцооны үйл ажиллагаа, ЖДҮҮ дэмжих төлөвлөгөө, АХБ-ны хамгааллын бодлого, төслийн өргөдөл гомдын механизм, төслийн хэрэгжилтэнд орон нутгийн иргэдийн хяналт, зохин байгуулалтын ач холбогдол гэх мэт шаардлагатай мэдлэг мэдээллүүдийг өгөв.



Зураг 11: Төслийн 2-р үе шатны иргэдийн уулзалт

2. Нийгэм, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зам тээврийн осол хэрэг, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулав. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсүүдтэй хамтран 2021 онд Дамбадаржаа дэд төвийн нутаг дэвсгэрт орших Сүхбаатар дүүргийн 58-р сургууль, Дэнжийн Мянга дэд төвд орших Чингэлтэй дүүргийн 39, 49, 57, 61-р сургуулийн сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтыг зохион

байгууллаа. Сургалтад 6-15 насны 710 хүүхэд хамрагдсанаас 424 буюу 59,7% нь охид байв. Энэхүү сургалтаар хүүхдүүд замын хөдөлгөөнд оролцох аюулгүй байдлын үндсэн дүрмүүдэд суралцав.



Зураг 12: Хүүхдүүдэд зориулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт

Мөн 77 (48 эмэгтэй) иргэнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт явуулав. Энэхүү сургалтаар насанд хүрэгчдэд явган зорчигч болон жолоочийн хувьд баримтлах ёстой замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн дүрмүүдийг сануулж, бага насны хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс хамгаалах аргачлалуудыг танилцуулсан.

3. 2021 онд жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төслийн 2-р үе шатны 3 гүйцэтгэгч компанийн ажилчид, хүний нөөцийн ажилтнуудад жендэрийн тэгш байдал, хууль эрх зүйн орчин, жендэрийн ялгаварлан гадуурхалт, АХБ-наас жендэрийн талаар баримтлах бодлогын талаар анхан шатны ойлголт, ажлын байран дахь хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг зэрэг цогц сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 16 (4 эмэгтэй) хүн хамрагдлаа.,
4. Төслийн ядуурал, нийгмийн үнэлгээний дагуу төсөл хэрэгжиж буй орон нутагт барилгын компанийн ажилчид ирж ажиллахтай холбоотойгоор биеэ үнэлэлт, бэлгийн замын халдварт өвчний тархалт ихсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэн жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд барилгын талбайд ажиллах ажилчид болон орон нутгийн иргэдийг ДОХ/ХДХВ болон бусад бэлгийн замаар дамжих халдварлах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулав. Монголын ДОХ-той тэмцэх нийгэмлэгтэй хамтран 67 (36 эмэгтэй) иргэнд сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулав.
5. Мөн дэд төвүүдэд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулж, нийт Дамбадаржаа дэд төвийн 179 (100 эмэгтэй) иргэнийг хамруулав. Сургалтын үр дүнд оролцогчид жендэр болон жендэрт суурилсан хүчирхийллийн талаар анхан шатны ойлголттой болж, хүчирхийлэлд өртсөн тохиолдлын талаар мэдсэн эсвэл хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэнд хандах талаар ойлголттой боллоо.
6. Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүдийн иргэдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Монгол Өрх” ТББ-тай хамтран 3 цуврал брошур бэлтгэн 3000 ширхэг хэвлэж, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт болон уулзалтуудын үеэр тарааж байна.



Зураг 13: Төслийн хүрээнд бэлтгэн гаргасан брошурууд

7. Төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн зорилтот бүлгийн өрхүүдийн амьжиргааг дэмжих зорилгоор “Өрхийн амьжиргаа дэмжих техникийн туслалцааны төсөл”-ийг Төсөл хэрэгжүүлэх нэгж хэрэгжүүлж байна. 2021 онд төслийн нөлөөлөлд өртсөн Дамбадаржаа дэд төвийн 36 өрхөд өрхийн хэрэгцээ тодорхойлох судалгаа хийж, зөвлөлдөх уулзалт хийгээд байна. Үүнээс 4 өрхийн 3 эмэгтэй, 1 эрэгтэй гишүүн хөтөлбөрт хамрагдаж, 2 сургалт, 3 тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан байна.
8. Төслийн хүрээнд 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 23-ны өдрийн хооронд нийт 105 хүсэлт, өргөдлийг төслийн 1 болон 2-р үе шатны дэд төвүүдийн иргэдээс ирүүлсэн ба санал хүсэлтийн төлөв байдлыг судалж үзвэл газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн тухай 15, мөсөн халиа, үер усны тухай 5, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох тухай 5, нөхөн сэргээлт 33, барилга угсралттай холбоотой 23, түр суурьшуулах байранд хамрагдах тухай 2, эко нойлны тухай 1, бүтэн өртөх тухай 6, газрын үнэлгээ, нөхөх олговрын тухай 3, цэцэрлэгт хамрагдах тухай 1, хот төлөвлөлтийн тухай 9, цахилгаанд холбуулах тухай 1, дэд бүтцийн ажлын ашиглагч байгууллагын тухай 1 өргөдлийг тус тус ирүүлсэн байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж нийт 103 өргөдлийг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 60 өргөдлийг иргэний талд шийдвэрлэлээ. Шийдвэрлэлтийн хугацааны хувьд 98,7%-тай буюу 99 өргөдлийг 30 хоногийн дотор буюу хугацаандаа шийдвэрлэж, иргэнд хариуг хүргүүлсэн байна.

Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаа

1. ЖДҮҮ эрхлэгчдийг сургах, чадавхижуулах арга хэмжээ:
 - Танхимын сургалт: ЖДҮҮ эрхлэгч 79 иргэн, ААН-д сургалт явуулсан бөгөөд үүний 54 нь буюу 68.4% нь эмэгтэй байна.
 - Онлайн сургалт: ЖДҮҮ эрхлэгч 58 иргэн, ААН-д онлайнгаар сургалт явуулсан бөгөөд үүний 26 нь буюу 44.8% нь эмэгтэй байна.
 - Сургалтын материал, зурагт хуудас бэлтгэн цаасаар болон олон нийтийн сүлжээ ашиглан хүргэх: 34 онлайн сургалтын материал, жишиг компани, хоршооны дүрэм, мэдлэг олгох зурагт хуудас зэргийг бэлтгэж 600 гаруй ЖДҮҮ эрхлэгч нарт хүргэсэн.
 - Загвар бизнес төлөвлөгөөгөөр хангах: Дэд төвийн иргэд, ААН-ийн түгээмэл эрхэлдэг цайны газар, хүнсний дэлгүүр, мужааны цех, бууз баншны цех, талх нарийн боовны цех, оёдлын цех, пакеталсан цай үйлдвэрлэх, гутал засварын цех, цэвэр ус савлах үйлдвэр, үсчний салон ажиллуулах гэх мэт бизнесийн чиглэлүүдэд зориулсан загвар бизнес төлөвлөгөөг боловсруулан 54 ЖДҮҮ эрхлэгчид илгээгээд байна. Ингэснээр ЖДҮҮ эрхлэгчид загвар төсөл дээр тулгуурлан богино хугацаанд өөрийн бизнес төлөвлөгөөг боловсруулах, бизнес төлөвлөгөө боловсруулах туршлага, чадавх суух боломж нэмэгдэж байгаа юм.
2. Ажлын байр нэмэгдүүлэх:

Ажилд зуучлах нээлттэй өдөрлөг: 2021 оны 11-р сард зохион байгуулагдсан “Ажилд зуучлах нээлттэй өдөрлөг”-т Дамбадаржаа дэд төвийн буюу Сүхбаатар дүүргийн 16, 17-р хорооны нийт 60 ажил хайгч иргэд хамрагдсан байна. Үүний 24 /40%/ эрэгтэй, 36 /60%/ нь эмэгтэй оролцогчид байна.



Зураг 14: Ажилд зуучлах нээлттэй өдөрлөг

Бараа үйлчилгээ нийлүүлэх үйл ажиллагааг дэмжих: Төслийн хүрээнд ажил гүйцэтгэгч ААН-үүдэд бараа, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах боломжийн талаар ЖДҮҮ эрхлэгчдэд сургалт мэдээлэл өгч, бараа үйлчилгээ нийлүүлэхэд шаардлагатай гэрээний төслүүдийг 49 ЖДҮ эрхлэгч нарт өгсөн болно.

Ажил үйлчилгээ гүйцэтгэгч компаниудаас ирүүлсэн мэдээллээр Набсан ХХК 2.1 сая төгрөгийн бараа үйлчилгээг дэд төвийн иргэд, ААН-ээс авсан байна.

Ажлын байр нэмэгдүүлэх бусад төсөл хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх: Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсүүдтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг газруудтай хамтарсан сургалт хийж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээл, хөтөлбөрт хамрагдах үе шат, арга замын талаар 3 удаа сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 20 хүн хамрагдсан байна. Бизнесийн зөвлөл байгуулах, чадавхижуулах

Дэд төвийн бизнес эрхлэгчдийг төслийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх, төслөөс үр ашиг хүртэх, хяналт тавих тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор бизнес эрхлэгчдийн төлөөллийг нэгтгэсэн бизнесийн зөвлөлийг Дэнжийн мянга болон Дамбадаржаа дэд төвүүдэд байгууллаа. Дамбадаржаа дэд төвийн бизнес зөвлөлд 9 гишүүнтэй, Дэнжийн дэд төвийн бизнес зөвлөл 8 гишүүнтэй байна. Тус зөвлөлүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ төслийн үйл ажиллагаанд хяналт тавих, санал хүсэлтээ төсөлд тусгах, оролцох, үр ашиг хүртэх боломж, процессын талаар сургалт хийж чадавхижуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулав:

- Дамбадаржаа дэд төвийн бизнес эрхлэгчдийн зөвлөл: Тус дэд төвийн зөвлөл нь “Дамбадаржаа ирээдүй бизнес зөвлөл” нэртэйгээр 2021 оны 11-р сард ТББ хэлбэрээр байгуулагдсан бөгөөд тэргүүлэх гишүүдийн 78% нь эмэгтэй гишүүнчлэлтэй байна.
 - Дэнжийн дэд төвийн бизнес эрхлэгчдийн зөвлөл: Тус дэд төвийн бизнес зөвлөл нь “Хөдөлмөрч сайн иргэд” нэртэйгээр 2021 оны 12-р сард ТББ хэлбэрээр байгуулагдсан бөгөөд тэргүүлэх гишүүдийн 62.5% нь эмэгтэй гишүүнчлэлтэй байна.
3. Сэлбэ дэд төвийн бизнес инкубатор төвийг түшиглэн Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төвтэй хамтран маркетинг, борлуулалт, санхүү, мэдээллийн технологийн дэвшлийг бизнест ашиглах боломж, бизнес төлөвлөлт, хүний нөөц, харилцааны ур чадвар зэрэг сэдвүүдээр Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвийн нийт 328 ЖДҮҮ эрхлэгчдэд чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулав. Үүний 248 буюу 76.6% нь эмэгтэйчүүд байна.

Олон нийтийн оролцооны үйл ажиллагаа

4. Дамбадаржаа дэд төвд иргэдийн оролцоог хангах үйл ажиллагаа 2021 оны 9-р сараас эхлэв. 2021 оны 12-р сарын байдлаас Дамбадаржаа дэд төвийн иргэдийг төслийн мэдээллээр хангах, иргэдийн оролцоо хангахад чиглэгдсэн 40 удаагийн цуврал уулзалтууд, арга хэмжээг зохион байгуулж 881 иргэд хамрагдаад байна. Үүний 61.5% нь эмэгтэй оролцогчид байна. Үүнд:
5. Дамбадаржаа дэд төвийн ажлын явцын талаарх танилцуулга уулзалт.

2021 оны 10-р сарын 15-ний өдөр Сэлбэ дэд төвийн Бизнес инкубатор төвийн хурлын танхимд төслийн явцын талаар Дамбадаржаа дэд төвд хамрагдах хорооны ажилтан, албан хаагчид болон иргэдэд мэдээлэл өгөх 2 удаагийн уулзалтыг зохион байгууллаа. Нийт 62 хүн оролцсоноос 56.5% нь эмэгтэйчүүд байна. Уулзалтаар төслийн танилцуулга Дамбадаржаа дэд төвд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын танилцуулга, авто зам, цэвэр усны шугамын ажил, замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийгмийн чиглэлийн төсөл хөтөлбөр, олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэсэн.



Зураг 15: Төслийн явцын мэдээлэл өгөх уулзалт

6. Дэд төвийн хөгжилд иргэдийн оролцоо ба хяналт уулзалт

2021 оны 12-р сарын 16-17ний өдрүүдэд өдөрт 2 ээлжээр буюу нийт 4 удаагийн уулзалтыг Сэлбэ дэд төвийн Бизнес инкубатор төвийн хурлын танхимд зохион байгуулсан. Уулзалтын зорилго нь дэд төвийн иргэдэд төслийн үр шимийг ойлгуулах, олон талт мэдээллээр хангах, санал солилцох байсан. Уулзалтад нийт 86 хүн оролцсоноос 60% нь эмэгтэйчүүд байна. Уулзалтаар төслийн 2-р үе шатанд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын танилцуулга, явц, газар чөлөөлөлт, нийгмийн чиглэлийн төсөл хөтөлбөр, олон нийтийн оролцоо ба хяналт, замын хөдөлгөөний аюулгүй байдал, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь, ДОХ, БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх нь, санал хүсэлтийн механизм зэрэг олон талт мэдээлэл хүргэсэн.

Иргэдийн бүлэг байгуулах, бэхжүүлэх уулзалтууд

Дамбадаржаа дэд төвд 2020 онд хийгдсэн цахим аяны хүрээнд цахим хэлбэрээр 8 иргэдийн бүлэг үүссэн байсан. Үүнээс 4 бүлэг газар чөлөөлөлтөд өртөн нүүж 4 бүлэг үлдсэн. Эдгээр 4 бүлгийг идэвхжүүлэх, бүтцийг өөрчлөх, шинээр иргэдийн бүлэг байгуулах нийт 25 удаагийн иргэдийн уулзалтыг зохион байгуулж 337 хүн хамрагджээ. Үүний үр дүнд тус дэд төвд нийт 304 гишүүдтэй 23 иргэдийн бүлэг албан ёсоор байгуулагдсан.



Зураг 16: Дамбадаржаа дэд төвд хийгдсэн иргэдийн бүлгийн уулзалтууд

2021 оны 11-р сарын 4 өдөр Дамбадаржаа дэд төвд 23 бүлгийн ахлагч, нарийн бичиг нараас бүрдсэн “Дамба дэвшил” Оршин суугчдын зөвлөл (ОСЗ) байгуулагдсан. Оршин Суугчдын Зөвлөлийн ээлжит хурал 2021 оны 12-р сарын 3 өдөр “Тийн челлэнж Монгол” төвийн уулзалтын өрөөнд зохион байгуулагдсан. Уулзалтад тус дэд төвийн газрын эздийн 13 бүлгийн ахлагч, нарийн бичиг нараас бүрдсэн 23 хүн хамрагдлаа. Уулзалтаар дэд төвийн танилцуулга, жендэрт суурилсан хүчирхийлэл, санал хүсэлтийн механизм, олон нийтийн оролцоо, хяналт зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч, нийт гишүүд оршин суугчдын зөвлөлийн дүрмээ хэлэлцэн, удирдах зөвлөлийн гишүүд, хяналтын зөвлөлийн гишүүдээ томиллоо. “Дамба дэвшил ОСЗ” ТББ үүсгэн байгуулах, дүрмээ батлах, гишүүдээ томилох, гишүүдийн эрх үүргийг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, төслийн мэдээлэл авах уулзалт 2021 оны 12-р сарын 25 өдөр Сэлбэ дэд төвийн Бизнес инкубатор төвийн хурлын танхимд зохион байгуулагдсан. Уулзалтад 23 бүлгийн 37 ахлагч, нарийн бичиг нар хамрагдлаа. Уулзалтаар 2022 оны ТББ-ын зорилго, төлөвлөгөөг хэлэлцэн гаргаж тулгарч болох эрсдэл түүнийг хэрхэн даван туулах боломжоо тодорхойлон гаргав. Нийт бүлгийн гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хийж ажиллахаар болов. Нийт гишүүд төслийн танилцуулга, санал гомдол барагдуулах механизм, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар мэдээлэл авсан.

Зураг 17: “Дамба дэвшил” ОСЗ-ийн гишүүд дүрмээ баталж буй нь

1. “Дамба дэвшил” ОСЗ нь ТББ болон албажих ажил хийгдэж байна. ОСЗ-ийн нийт гишүүдийн хурлыг 3 удаа зохион байгуулж ТББ-ын дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналтын зөвлөл, барилгын хороо, гишүүдийн татвар, удирдах зөвлөлийн гишүүд, ТББ-ын удирдлагуудыг сонгон баталсан. ТББ-ын логог эхний байдлаар гаргасан байгаа бөгөөд олны саналаар сайжруулалтын ажил хийгдэж байна.
2. “Дамба дэвшил” ОСЗ-ийн бүтцэд 3 хүний бүрэлдэхүүнтэй “Хяналтын зөвлөл” байгуулагдсан бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажлын үеэр олон нийтийн оролцоотой хяналтыг ажлыг хариуцан хийхээр тогтсон. Хяналтын зөвлөлийн гишүүд

болон ОСЗ-ийн нийт гишүүдэд олон нийтийн оролцоотой хяналт сэдэвт уулзалтыг 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 146 гишүүд хамрагдсан байна.



Зураг 18: “Дамба дэвшил ОСЗ” Төрийн Бус Байгууллагын гишүүд

3. Дамбадаржаа болон Дэнжийн мянга дэд төвүүдийн иргэдэд цахимаар мэдээлэл түгээх, санал солилцох зорилгоор 4 Фейсбүүк группыг үүсгэсэн бөгөөд 2021 оны эцсийн байдлаар 1137 гишүүдтэй байгаа бөгөөд эдгээр группуудээр дамжуулж төслийн танилцуулга, олон талын мэдээ мэдээллийг нийтлэх, уулзалт сургалтуудын зар түгээх, санал солилцох зэргээр ажилласан.

ХӨТӨЛБӨРИЙН ГУРАВ ДУГААР ҮЕ ШАТ – ТОЛГОЙТ, ШАРХАД ДЭД ТӨВ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн 3-р үе шатны хүрээнд (i) Хотын зүүн хэсгийн гэр хорооллын **Шархад, Толгойт** дэд төвүүдийн дэд бүтцийг шинэчлэх, орон зайн бүтцийн өөрчлөлт хийж бусад дэд төвүүдтэй холбоно, (ii) нийгэм эдийн засгийн барилга байгууламж барих, (iii) чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн 3-р үе шатны дэд төвүүдээс нийт 15,799 хүн (4,329 өрх) үр шим хүртэнэ. Үүнээс Толгойт дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 34 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 153 га талбайд 6,860 хүн 1846 өрх, Шархад дэд төв буюу Баянзүрх дүүргийн 8, 9, 10, 17, 19, 24 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 124 га талбайд 8,939 хүн, 2483 өрх амьдарч байна.

Хөтөлбөрийн 3 үе шатны Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд Tranche 3 үе шатанд хамрагдах Толгойт, Шархад дэд төвүүд дээр БОАЖЯ-наас Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулан авсны үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэж, 2020 оны 6-р сард БОАЖЯ-аар батлуулсан.

Үе шат 3-ын зээлийн хэлэлцээрийг 2020 оны 12 сарын 30-нд батлуулсан.

Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая ам.доллараар/

Эх үүсвэр	Санхүүжилт	Эзлэх хувь
АХБ-ны санхүүжилт		
МОН-3946 (COL)	18.60	16.29
МОН-3947 (OCR)	25.05	21.93
Дэд дүн	43.65	38.22

НЗДТГ-ын төсөв	51.90	45.45
ЕХОБ-ны санхүүжилт FI'83873	18.65	16.33
Нийт	114.20	100


№	Үндсэн үйл ажиллагаа	Төлөвлөсөн
А. Суурь зардал		94.40
I	<i>Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх</i>	77.06
1.1	Автозам сайжруулах	50.92
1.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	15.34
1.4	Дулааны шугам сүлжээ, үйлчилгээг сайжруулах	10.80
II	<i>Эдийн засгийн болон нийгмийн байгууламжийг нэмэгдүүлэх</i>	14.05
III	<i>Байгууллагыг чадавхижуулах</i>	3.29
Б. Магадлашгүй ажил		16.62
В. Хэрэгжүүлэх үеийн санхүүгийн хураамж		3.18
Нийт дүн		114.20

Хөтөлбөрийн 3-р Үе шатыг дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх
2. Нийгэм, эдийн засгийн барилга байгууламжууд
3. Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

2021.09.01-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 20 барилгын ажил, 1 бараа, 3 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 1 барилгын ажил, 2 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна.



Одоогийн байдлаар дараах ажлуудын худалдан авалтын үйл ажиллагааг эхлүүлээд байна.

№	Ажлын нэр	Худалдан авалтын явц
1	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил	Тендерийг 2021 оны 11-р сарын 17-нд зарласан. Материал хүлээн авах эцсийн хугацаа 2021 оны 12-р сарын 17-нд товлотсон. Товлосон хугацаанд нэг санал хүлээн авсан. Үнэлгээний хороо үнэлгээг эхлүүлж тайлан боловсруулж байна

2	Сонгинохайрхан дүүрэг 1, 2, 20-р хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил	Үнэлгээний хороог 2021 оны 11-р сарын 30-нд байгуулсан. Тендерийн баримт бичгийг боловсруулж байна
---	--	--

Худалдан авалтын үйл ажиллагааны явц 7%-тай байна.

Энэхүү үе шатны хүрээнд байгуулсан гэрээний хэрэгжилтийн мэдээллийг **Хавсралт 6-д** үзүүлэв.

10. Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд:

2021 оны 6 сард ажилласан АХБ-ны ажлын хэсгийн санамж бичгийг холбогдох талуудаар албажуулах

Хөтөлбөрийн I үе шатны ажлуудыг бүрэн дуусган улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах

Хөтөлбөрийн II үе шатны зураг төслийн ажлуудыг эрчимжүүлэн зураг төслийг 2022 оны 1р улиралд багтаан дуусгахаар ажиллах

Хөтөлбөрийн III үе шатны зураг төсөл боловсруулалтын ажлуудыг эрчимжүүлэх

11. Тулгамдаж буй асуудлууд:

Төслийн хэрэгжилтийг удаашруулж буй дараах асуудлууд байна. Үүнд:

№	Тулгамдаж буй асуудал	Асуудлын шалтгаан	Гарч буй үр дагавар
2	2022 оны төсөвт барилга угсралтын болон ГЧНШ-ын ажлуудын Нийслэлийн хариуцах санхүүжилт болох 166.8 тэрбум төгрөг шаардлагатай	Хөтөлбөрийг 2023 онд бүрэн хэрэгжүүлэх дуусгахын тулд 2022 оны НЗДТГ-ын төсөвт ГЧНШ-ын нөхөн олговрын төлбөр болон нийслэлийн хариуцах барилгын ажлуудын төлбөр	-
	Худалдан авалтын үйл ажиллагааг худалдан авалтын системийн дагуу хийгддэг болж байгаа тул ТУХ-г хуралдуулж төслийн төлөвлөгөөнүүдийг батлуулах шаардлагатай		
3	Шархад дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох техникийн нөхцөл авах	Амгалан дулааны станцын одоогийн хүчин чадал хүрэлцээгүй, өргөтгөлийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, техникийн нөхцөл олгох боломжгүй	Амгалан дулааны станцын өргөтгөлийн ажил хэзээ хийгдэх нь тодорхойгүй, санхүүжилт шийдэгдээгүй

4	2020 оны эцэс болон 2021 онд байгуулагдсан гэрээт ажлуудын төсөвт өртөг нэмэгдэх, үнийн өсөлт, санхүүгийн хүндрэлээс шалтгаалж, ажлууд зогсонги байдалд орох	Барилгын салбарт арматур /30 гаруй хувиар/, цемент, ган яндан хоолой, төмөр хийц эдлэл, хөөсөнцөр гэх мэт үнэ БНХАУ, болон Монгол улсын дотоодын зах зээл дээр үнэ огцом нэмэгдсэн, 2 улсын хоорондох ачаа тээврийн удааширсан, зогссонтой холбоотой	- 2021 он гараад гэрээ байгуулагдсан гүйцэтгэгч нарын гэрээний хэлэлцээр болон барилга угсралтын ажлын явцад ирүүлж буй албан бичиг, мэдэгдлүүдэд дурдсанаар барилга угсралтын ажил нь зах зээл дээрх бодит бараа материалын үнийн өсөлт нь урьдчилан тооцоолоогүй, давагдашгүй шинж чанартай болж байгаа болон гадаад материал захиалгын хугацаа болон тээвэрлэлтийн үнэ нэмэгдсэн зэрэг нь ажлыг явуулах боломжгүй болгох, царцах, цаашид гэрээ цуцлагдах эрсдэлтэй байна.
	Барилга угсралтын ажилд ашиглагдах БНХАУ-аас оруулж ирэх бараа, материал хил, гааль дээр удаан хугацаанд саатаж байгаа асуудлыг шийдвэрлэх		-
	Төслийн 1, 2 дугаар үе шатны газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн түрээслээд өмчлөх орон сууцанд хамрагдах хүсэлт гаргасан газрын эрхгүй 68 иргэнийг “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын дагуу орон сууцанд хамруулах		-
	Төслийн 1 үе шатны хүрээнд хийгдэн 2018, 2019 онд бүрэн дууссан Баянхошуу дэд төвийн Усан сангийн ажил болон УСҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах ажлыг хүлээлгэн өгөх		-
	Сэлбэ дэд төвд 0.6 км хөрсний ус доошлуулах шугам, Сэлбэ дэд төвийн шинээр баригдсан авто замыг Хайлааст Дарь эхийн замтай холбох 0.9 км автозам, Сэлбэ дэд төвд 830м үерийн хамгаалалтын далан хийх ажлуудын зураг	Төслийн хэрэгжилтийн явцад төслийн үйл ажиллагаатай нягт холбоотой зайлшгүй хийгдэх шаардлагатай	-

	төслийг боловсруулах санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх		
	Дамбадаржаа дахин төлөвлөлтийн хүрээнд хийгдсэн ариутгах татуургын шугамд хөрсний ус нэвчсэн асуудлыг яаралтай засварлах	2021 оны эцсээр Сэлбэ дэд төвийн дулааны станц, ариутгах татуургын шугам ашиглалтад орохтой холбоотойгоор	-
	Дэнжийн мянга дэд төвийн 80 Гкал/ц хүчин чадалтай дулааны эх үүсвэр, өндөр хүчин чадлын дулаан дамжуулах төвийн барилга байгууламжийг барихад шаардлагатай 3.8 га газрыг чөлөөлөхөд шаардагдах 10.86 тэрбум төгрөг, дээрх барилга байгууламжийг барихад шаардлагатай 27.5 тэрбум, нийт 38.36 тэрбум төгрөгийн хөрөнгийг Улс, Нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах	Өвлийн оргил ачааллын үед төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолж ажиллах	-
	Амгалан дулааны станцыг дулаан хангамжийн хувьд хотын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахуйцаар өргөтгөхөд шаардлагатай хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх	Шархад дэд төвийн 507га газрын төлөвлөлтөөр дулаан хангамжийн 112.0 Гкал/ц дулааны ачаалал шаардлагатай байгаа	-

12. Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

2022 оны НЗДТГ-ын төсөвт 2020, 2021 оны хүлээгдэж буй төлбөрүүд болон 2022 онд барилгын ажилд шаардагдах санхүүжилтийг бүрэн тусгаагүйгээс төслийн ажлууд 2023 онд хэрэгжиж амжихгүйд хүрэх эрсдэл үүсэж байгаа тул төсвийн тодотголоор нэмэлт төсөв батлуулж өгөх шаардлагатай

13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:

- Төслийн захирлын нэр:** Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч
- Төслийн зохицуулагчийн нэр:** Д.Авирмэд
- Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу 1, Амарын гудамж 2, Соёлын төв өргөө, Г корпус #415



г. Холбоо барих утас: + (976)-7000-3099

д. Цахим шуудангийн хаяг: info@ub-subcenter.mn

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАГАЖ МӨРДӨЖ БҮЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Төслийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн баримт бичгүүдэд дараах баримт бичгүүд багтана. Үүнд:

1. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр (СЕХ) /2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Монгол УИХ-аар соёрхон баталсан/
2. СЕХ-ийн дагалдах баримт бичгүүд:
 - a. Үе шат 1-ийн санхүүжилтэнд хамаарах МУ-ын Засгийн Газар ба АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ:
 - i. Төслийн гэрээ МОН-3098, МОН-3099, МОН-0380 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - ii. Тусгай сангийн зээлийн гэрээ МОН-3099 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - iii. Ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3098 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - iv. Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээ МОН-0380 /2013 оны 6 дугаар сарын 30/
 - b. Үе шат 2-ын санхүүжилтэнд хамаарах МУ-ын Засгийн Газар ба АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ:
 - i. Төслийн гэрээ МОН-3525, МОН-3526(COL) /2017 оны 12 дугаар сарын 06/
 - ii. Концессийн ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3526(COL) /2017 оны 12 дугаар сарын 06/
 - iii. Ердийн эх үүсвэртэй санхүүжилтийн зээлийн гэрээ МОН-3525/2017 оны 12 дугаар сарын 06/
 - c. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу МУ ба Европын Хөрөнгө Оруулалтын Банктай байгуулсан зээлийн гэрээ FI83.097, FI83.873 /2013 оны 6 дугаар сарын 30, Төслийн үе шат 1,2-т хамаарна/
 - d. Олон шатлалт санхүүжилтийн зээлийн шугам (ОШСЗШ)-ын удирдлагын баримт бичиг /АХБ-ны Удирдах Зөвлөлөөс 2013 оны 08 дугаар сард баталсан, Төсөл 2-т холбогдуулан 2017 оны 3 дугаар сард шинэчлэн баталсан/
3. МУ-ын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Хөтөлбөрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс дэд төвүүдийн иргэдэд төслийн үйл ажиллагааг танилцуулах, явцын мэдээлэл өгөх зэргээр олон удаагийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж улирал тутмын сонинг тараан ажилласан.

Төслийн үйл ажиллагаан тайланг улирал бүрээр, барилгын ажлын явцын мэдээллийг сар бүр бэлтгэн төслийн оролцогч талуудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргэж ажиллаж байна.

Хөтөлбөрийн цахим хуудсанд www.ub-subcenter.mn байрлах мэдээллийг дараах байдлар төрөлжүүлсэн.

1. Үйл ажиллагааны ил тод байдал

Хөтөлбөрийн үйл ажиллагааны явцын тайлан мэдээг байршуулдаг.

2. Хүний нөөцийн ил тод байдал

Төслийн нэгжийн хүний нөөцийн холбогдолтой мэдээллүүд буюу нээлттэй ажлын байрны зарууд, анкетын загвар, байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрэм, ажилд сонгон шалгаруулах журам зэрэг мэдээллийг байршуулдаг.

3. Албан хаагчдын утасны жагсаалт

Төслийн нэгжийн ажилчдын холбоо барих мэдээлэл, өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн холбоо барих мэдээлэл зэргийг байршуулсан.

4. Шилэн данс

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014)-ийн дагуу төслийн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn холбогдох мэргэжилтнүүд тодорхой хугацаанд нь байршуулж ажиллаж байна.

Хөтөлбөрийн цахим хуудсыг ажиллуулж мэдээлийг тогтмол шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд нийгмийн сүлжээгээр төслийн үйл ажиллагааны явц, онцлох мэдээ мэдээллийг цаг алдалгүй нийтэлж ажиллаж байна. ([FB page: Гэр Хорооллыг Хөгжүүлэх Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр Төсөл](#))

ХАВСРАЛТ 1. ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ

Хөтөлбөрийн 1-үе шатны хүрээнд байгуулсан гэрээ болон түүний хэрэгжилтийн явц

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Бодит явц*
				Эхлэх	Дуусах	
Бүрэлдэхүүн 1			69,308,428.82			
	АХБ-ны зээл		48,144,626.57			
1	SHF06	Сэлбэ Дулааны станц, 26МВт, 1ш	6,955,959.15	7/17/2017	11/24/2021	91%
2	SRDH14	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - үе шат 2	6,772,427.72	9/11/2017	6/15/2021	100%
3	SRDH11	Сэлбэ Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	8,401,254.11	2/23/2018	6/30/2021	100%
4	BHF06	Дулааны шугамын өргөтгөл шинэчлэл	3,681,207.64	9/3/2018	12/15/2019	100%
5	BRDH14	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 2	8,739,166.72	10/29/2018	6/30/2021	95%
6	SBR08	Сэлбэ дэд төвийн Гүүр	1,051,071.02	10/15/2018	6/30/2020	100%
7	BRDH11	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1	7,578,811.17	11/16/2018	6/30/2021	100%
8	BEC13	Баянхошуу Цахилгаан, холбооны шугам сүлжээ	2,391,473.52	11/16/2018	6/15/2021	98%
9	SEC13	Сэлбэ Цахилгаан, холбооны шугам сүлжээ	2,573,255.52	12/18/2018	6/15/2021	98%
	ЕХОБ-ны санхүүжилт		21,163,802.25			
10	SCM	Сэлбэ Бохирын гол шугам (EIB)	1,040,806.74	4/14/2016	8/1/2017	100%
11	BCM1	Баянхошуу 1	1,279,862.99	5/15/2016	11/30/2016	100%
12	BCM2	Баянхошуу 2	932,078.01	8/29/2016	11/30/2016	100%
13	WWTPR01	Төв цэвэрлэх шинэчлэл	2,281,585.32	9/14/2017	8/1/2019	100%
14	WSNR17C	Орос 14-өөс төвийн шугам	219,314.27	10/11/2017	8/1/2019	100%
15	BSDF07 Lot 1	Үерийн хамгаалалт, далан суваг (EIB)	457,178.95	11/21/2017	5/6/2018	100%
16	BSDF07 Lot 2	Үерийн хамгаалалт, далан суваг (EIB)	788,688.27	11/21/2017	9/30/2020	100%
17	BSPE	Яндан хоолой нийлүүлэх	1,483,848.70	11/12/2017	5/6/2018	100%
18	BSWR10 Lot 2	Усан сан (EIB)	1,139,163.25	12/5/2017	6/30/2020	100%
19	BSWR10 Lot 1	Баянхошуу Усан сан	1,862,831.02	12/5/2017	6/30/2020	100%
20	WSNR17A	Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх ,	3,615,614.09	1/23/2018	9/30/2022	60%
21	WSNR17B	Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх7054м	2,587,015.56	4/11/2018	9/30/2022	84%
22	WSC16A	Салбар шугамын холболт	2,047,228.80	7/24/2019	6/30/2021	100%
23	BSDF07B	Баянхошуу Үерийн хамгаалалтын суваг, шинэ	2,469,393.02	8/20/2019	6/20/2021	100%
Бүрэлдэхүүн 2			8,594,217.37			

1	BSF Lot 1	БАГЦ 1 - 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	1,064,577.84	9/17/2017	9/19/2018	100%
2	BSF Lot 2	БАГЦ 2 - МСҮТ, бизнес инкубаторын барилга	1,299,502.98	9/22/2017	9/22/2018	100%
3	BFGA	Баянхошуу цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	60,421.00	10/19/2018	11/16/2018	100%
4	SSF Lot 1	БАГЦ 1 - 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга	1,053,871.33	1/17/2019	5/31/2020	100%
5	SSF Lot 2	БАГЦ 2 - МСҮТ, бизнес инкубаторын барилга	855,238.33	1/17/2019	5/31/2020	100%
6	BEF	Баянхошуу бизнес инкубаторын тавилга, тоног төхөөрөмж	71,977.00	3/26/2019	4/16/2019	100%
7	BSLS09 Lot 2	Сэлбэ Тохижилт, ландшафт, 3.01га	1,380,356.23	3/25/2019	6/17/2020	100%
8	BSLS09 Lot 1	Баянхошуу Тохижилт, ландшафт, 4.65 га	1,127,264.57	8/2/2019	9/2/2020	100%
9	SEF	Сэлбэ бизнес инкубаторын тавилга, тоног төхөөрөмж	103,426.00	6/26/2020	7/20/2020	100%
10	SFGA	Сэлбэ цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж	50,933.00	7/23/2020	8/23/2020	100%
11	PP01-SW	Баянхошуу дэд төвд Орлогд нийцсэн орон сууцны туршилт, 20 айлын орон сууц, 1ш	846,555.94	8/21/2020	11/21/2021	95%
12	TFBA	Чөлөөлсөн талбайг хашаалах НОСК, 1500м	73,200.00	12/25/2020	11/21/2021	100%
13	SCBA	Баянхошуу дэд төвд НОСК-ын чөлөөлсөн талбайг цэвэрлэх	53,936.84	9/6/2021	11/30/2021	100%
14	SHPM	Truck and machinery for Selbe heating plant (Lot1&2)	269,857.86	6/29/2021	11/26/2021	50%
15	SHPOF	Office equipment and furniture for Selbe heating plant	63,381.05	3/24/2021	5/10/2021	100%
16	SHPOV	Vehicles for operation of Selbe heating plant	75,877.19	7/28/2021	10/28/2021	50%
17	SHPSW	PPE, fire protection, and tools for the operation of Selbe heating plant (Lot1,2&3)	143,840.21	5/5/2021	8/6/2021	70%
Бүрэлдэхүүн 3			3,698,952.00			
1	WWOI	УСУГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ (Буцалтгүй тусламж)	3,698,952.00	10/13/2016	9/30/2018	100%
Бүрэлдэхүүн 4			10,361,661.81			
	АХБ-ны зээл		9,978,434.02			
1	ICS1-3	Олон улсын зөвлөхүүд	165,796.11	1/1/2015	1/1/2016	100%
2	NCS4-9	Дотоодын зөвлөхүүд		1/1/2015	1/1/2016	100%
3	CS/CSDD	Инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	3,084,029.00	5/29/2015	7/2/2018	100%
4	CS2/CSPM	Төслийн удирдалагад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ	1,274,807.67	6/5/2015	6/5/2018	100%
5	CS3/CSCE	Олон нийтийн оролцоог хангах ЖДҮ-г хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ	749,603.00	6/25/2015	6/30/2018	100%
6	CS4/CSSD	Хотын төлөвлөлт болон дэд төвийн төлөвлөлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ	780,078.48	8/28/2015	6/30/2018	100%

7	CSBHF06A	Дулааны шугам сүлжээний өргөтгөлийн зураг төсөл боловсруулах	62,129.78	5/18/2018	11/19/2018	100%
8	CS CSDS	Сэлбэ дулааны станцын ТЭЗҮ, Баянхошуу Сэлбэ дэд төвүүдийн инженерийн гадна холбоосны зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	196,072.96	10/19/2018	11/19/2019	100%
9	PP01 DD	Орлогд нийцсэн орон сууцны зураг төсөл боловсруулах	69,520.00	1/29/2019	9/15/2019	95%
10	CSDA	Зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ	899,997.50	6/25/2019	3/25/2021	95%
11	ES-COL OCR	Захиалагчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ	846,954.76	6/27/2019	12/31/2020	95%
12	CSO1	Хотын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ	438,508.00	12/20/2019	2/12/2021	100%
13	SHPTC	Сэлбийн дулааны насос станцын туршилт тохируулга	186,880.00	7/26/2021	12/30/2021	98%
14	CS6/EEM	Байгаль орчны хөндлөнгийн мониторинг хийх зөвлөх үйлчилгээ	25,140.00	5/21/2021	11/21/2021	100%
15	PMO staff		1,198,916.76			100%
	ЕХОБ-ны санхүүжилт		383,227.79			
16	DS-NHOG	Зураг төслийн ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	166,613.58	1/21/2019	12/30/2021	92%
17	ES-NHOG	Барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ	216,614.21	5/31/2018	12/30/2021	92%
	Хөтөлбөр 1		91,963,260.00			

ХАВСРАЛТ 2. ХӨТӨЛБӨРИЙН 1 ДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ БАРИЛГЫН АЖЛУУД

I ҮЕ ШАТ

Сэлбэ дэд төв

- Авто зам-6.8 км
3 гүүр: 24м, 30м, 60м
- Дулаан шугам-9.97 км
- УДДТ-15 ш; ХТП-3 ш
- Цэвэр усны шугам-9.34 км

- Бохир усны шугам-15 км
- 35/10кВ дэд станц, цахилгааны шугам-3.5 км холбооны шугам-5.5 км
- 3.01 га тохижилт, ногоон байгууламж, УХС -2.1 км

БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

- 1 Сэлбэ дулааны станц 28 мВт
- 2 Бизнес инкубатор, сургалтын төв
- 3 Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилга
- 4 240 хүүхдийн ортой цэцэрлэг
- 5 1000м3 Усан сан, насос станц барилга



БАЙРШИЛ

СБД-ийн 13, 14-р хороо, ЧД-ийн 14, 18-р хороо /156га/



ХҮН АМ

Одоогийн байдал		Төлөвлөлт /2040/	
Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх
10910	2920	23500	6520



I ҮЕ ШАТ. СЭЛБЭ ДЭД ТӨВ

Сэлбэ дэд төвд баригдсан авто зам болон инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил



Гэрээний дугаар: SRDH11, SRDH14, SBR08

Хүчин чадал, үзүүлэлт:

Цэвэр усны шугам – 11.9км;
Бохир усны шугам – 12.8км;
Авто зам – 6.6км;
Дулааны шугам – 9.97км;
Ус дулаан дамжуулах төв – 14ш;
Гүүр – 3ш





I ҮЕ ШАТ. СЭЛБЭ ДЭД ТӨВ



Сэлбэ дэд төвийн 28 мВт Дулааны станц




11



I ҮЕ ШАТ. СЭЛБЭ ДЭД ТӨВ

Сэлбэ дэд төвийн 2.3 км үерийн хамгаалалтын суваг, үерийн хамгаалалтын суваг дагуух тохижилт



I ҮЕ ШАТ

Баянхошуу дэд төв

- Авто зам-6.5 км
- Дулаан шугам-27.9 км
- УДДТ-14 ш; ХТП-5ш
- Цэвэр усны шугам-10.9 км

- Бохир усны шугам-15 км
- 35/10кВ дэд станц, цахилгааны шугам-6.3 км, холбооны шугам-2.9 км
- 4.65га тохижилт, ногоон байгууламж, ҮХС -4.7 км

- ### БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД
- 240 хүүхдийн ортой цэцэрлэг
 - Бизнес инкубатор, сургалтын төв
 - Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилга
 - 20 айлын орон сууцны барилга
 - 1000м3 Усан сан, насос станц барилга



БАЙРШИЛ

СХД-ийн 7, 8, 9, 10, 11, 28, 40-р хороо /162га/




ХҮН АМ

Одоогийн байдал		Төлөвлөлт /2040 он/	
Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх
8367	2197	29083	6463



I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ

Баянхошуу дэд төвд баригдсан авто, инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил



Гэрээний дугаар: BRDH11 болон BRDH14

Хүчин чадал, үзүүлэлт:

Цэвэр усны шугам – 5.1км;
Бохир усны шугам – 8.5км;
Авто зам – 6.8км;
Дулааны шугам – 7.7км;
Ус түгээх байр - 1ш;
Ус дулаан дамжуулах төв - 12ш;





I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ

Баянхошуу дэд төвийн дулаан хангамжийн ажил



Баянхошуу дэд төв

Дулааны шугам	5.5 км (2ф150-2ф300мм)
Ус дулаан дамжуулах төв	12 ш (1.6 – 5.7 Гкал/ц)
Салбар шугам	2.1 км (2ф50-2ф200мм)

Нийгмийн барилга байгууламж:

- 67 дугаар сургууль
- 117 дугаар цэцэрлэг
- Түр суурьшуулах орон 50 айлын сууц
- 76 дугаар сургууль
- 78 дугаар цэцэрлэг
- 163 дугаар цэцэрлэг
- СХД-ийн 3-р амбулатори
- СХД-ийн Цагдаагийн 2-р хэлтэс
- СХД-ийн 9-р хорооны барилга



I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ

Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд баригдсан цахилгаан, холбооны шугам сүлжээ, барилга угсралтын ажил


Ажлын нэр	БАЯНХОШУУ ДЭД ТӨВ	СЭЛБЭ ДЭД ТӨВ
35/10кВ-ийн дэдстанц	2*16 МВА иж бүрдэл	2*16 МВА иж бүрдэл
Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв	21*16 м хэмжээтэй 2 давхар барилга	21*16 м хэмжээтэй 2 давхар барилга
10кВ-ийн хуваарилах байгууламж	1 иж бүрдэл	-
10/0.4кВА хаалгтай дэд өртөө	2*630 кВА 2 иж бүрдэл	2*630 кВА 2 иж бүрдэл
Холбооны худаг, сувагчлал	3 км	3 км
35кВ-ийн кабель шугам	4.2 км	3.5 км
10кВ-ийн кабель шугам	2.3 км	0.55 км





I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ

Баянхошуу дэд төвийн 4.7 км үерийн хамгаалалтын суваг, үерийн хамгаалалтын суваг дагуух тохижилт



I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ

Баянхошуу дэд төвд баригдсан 1000М3 усан сан, насос станц, ус дамжуулах дамжуулах шугамын ажил

Гэрээний дугаар: BSWR10 lot1

Хүчин чадал, үзүүлэлт:

- Усан сан, $v=1000 \text{ m}^3$
- 2 насос станц, $h=70\text{m}$
- Ус дамжуулах шугам, $l=5.8 \text{ km}$



Дэд төвүүдтэй уялдаа холбоотой ажлууд


БАЯНЗҮРХ, БАЯНГОЛ, СҮХБААТАР, СОНГИНОХАЙРХАН, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ
ДЭВСГЭРТ БАРИГДАХ УС ХАНГАМЖИЙН Ø900ММ, Ø600ММ, АРИУТГАХ ТАТУУРГЫН Ø600ММ
ШУГАМ ХООЛОЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ



ЦЭВЭР УСНЫ ШУГАМ: 12.08 КМ,



АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМ: 1.7 КМ



I ҮЕ ШАТ. СЭЛБЭ ДЭД ТӨВ



240 хүүхдийн ортой цэцэрлэг



Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл
эрхлэгчдийн хөгжлийн төв





I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ



240 хүүхдийн ортой цэцэрлэг



Бизнес инкубатор, сургалтын
төвийн барилга



I ҮЕ ШАТ. БАЯНХОШУУ ДЭД ТӨВ

20 айлын орон сууцны барилгын загвар, төсөл



ХАВСРАЛТ 3. ХӨТӨЛБӨРИЙН 1 ДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ БАРИЛГЫН АЖЛУУД

I ҮЕ ШАТ

Дэд төвүүдтэй уялдаа холбоотой ажлууд

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН
ДУГУЙ РЕЗЕРВУАРЫН БАРИЛГА БОЛОН АЭРОТАНКИЙН
БЕТОН ХИЙЦИЙН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖИЛ

/2017.09.14 - 2018.12.01/



СКАДА СИСТЕМ, НАСОСНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ,
СУУРИЛУУЛАХ, НАСОС СТАНЦЫН УС, БОХИР УС ЦЭВЭРЛЭХ
БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧИЛЖ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

2018 ОНЫ 11 САРД БАЙНГЫН АШИГЛАЛТАД ОРУУЛЖ, УСУГ-Т ХҮЛЭЭЛГЭН ӨГӨВ.



ХАВСРАЛТ 4. ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ

Хөтөлбөрийн 2-р үе шатны хүрээнд байгуулсан гэрээ болон түүний хэрэгжилтийн явц

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Бодит явц
				Эхлэх	Дуусах	
Бүрэлдэхүүн 1			15,656,154.16			
	АХБ-ны зээл		8,961,290.00			
1	BHF06B	Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, дулааны даралт өргөх, насос станц, ус дулаан дамжуулах төв, дулааны шинэ шугамын зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	7,061,203	10/12/2018	9/30/2021	100%
2	GWD14	Сэлбийн хөрсний ус зайлуулах 2,2 км шугамын ажил	1,261,321	9/30/2019	6/7/2020	100%
3	GWD11	Сэлбийн хөрсний ус зайлуулах 1,3 км шугамын ажил	638,766	9/30/2019	6/7/2020	100%
	ЕХОБ-ны санхүүжилт		6,694,864.16			
4	WSC16B	Шархад дэд төвийн Цайз эко хотхон хорооллыг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам, халуун, дулааны шугам, болон цахилгаан хангамжийн шугамд холбох зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралтын ажил	2,006,608.00	5/22/2020	9/2/2021	100%
5	HSSC-A	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	82,355.82	10/1/2020	8/1/2021	100%
6	HSSC-B	2-р хэлхээний дулаан хангамж, хэрэгцээний халуун ус, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил	669,281.82	10/1/2020	10/1/2021	100%
7	USF	Морингийн даваа орчмын шинэ суурьшлийн бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	3,936,618.52	10/23/2020	10/23/2021	44%
Бүрэлдэхүүн 2			6,919,982.70			
1	LAE	Газрын албанд тоног төхөөрөмж	94,096.00	3/23/2020	5/11/2020	100%
2	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	3,553,648	11/18/2020	2/17/2022	42%
3	ASKG-BKH	240-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баянхошуу дэд төв/	1,403,408	2/9/2021	5/9/2022	11%

4	DDPK-BKH	2га талбайд Цэцэрлэгт хүрээлэн /Баянхошуу дэд төв /	836,929	3/1/2021	3/1/2022	60%
5	DDCD-BKH	Олон Нийтийн Хөгжлийн төв /Баянхошуу дэд төв/	1,031,901	3/1/2021	6/1/2022	13%
Бүрэлдэхүүн 3			13,088,797.81			
1	T2-CS01	Инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	5,689,155.00	11/16/2018	6/22/2022	31%
2	T2-CS02	Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж чадавх бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ	3,734,100.00	1/4/2019	1/4/2022	68%
	T2-CS05	Хөтөлбөрийн 3 дугаар үе шатны нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	3,566,500.00	12/25/2020	11/2/2023	
	T2-CS03	Байгаль орчны хөндлөнгийн мониторинг хийх зөвлөх үйлчилгээ	99,042.81	3/11/2021	9/11/2024	
Нийт			35,664,934.67			

ХАВСРАЛТ 5. ХӨТӨЛБӨРИЙН 2 ДУГААР ҮЕ ШАТНЫ БАРИЛГЫН АЖЛУУД

II ҮЕ ШАТ

Баянхошуу дэд төв



БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> 1 126 айлын орон сууцны барилга 2 Өргөлтийн насос станц 3 240 хүүхдийн цэцэрлэг 4 Гал түймэр унтраах, аврах 29-р ангийн шинэ барилга | <ul style="list-style-type: none"> 5 650 хүний суудалтай Спорт цогцолбор 6 Цэцэрлэгт хүрээлэн 7 Олон нийтийн хөгжлийн төв 8 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр |
|---|---|



II ҮЕ ШАТ

Дэд төвүүдийн нутаг дэвсгэрээс гадна

МОРИНГИЙН ДАВАА ОРЧМЫН ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙГ ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭРЭЭР ХАНГАХ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ



ХАВСРАЛТ 6. ГЭРЭЭ БАЙГУУЛАЛТЫН ЯВЦ

Хөтөлбөрийн 3-үе шатны хүрээнд байгуулсан гэрээ болон түүний хэрэгжилтийн явц

№	Багцын дугаар	Ажлын нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээний хугацаа		Бодит явц
				Эхлэх	Дуусах	
Бүрэлдэхүүн 1			1,655,582.86			
	ЕХОБ-ны санхүүжилт		1,655,582.86			
1	TFP	Толгойт дэд төвийн үерийн даван суваг	1,655,582.86	3/30/2021	5/30/2022	0%
Бүрэлдэхүүн 3			198,645.61			
1	T3-CS02	Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн хөндлөнгийн мониторинг хийх зөвлөх үйлчилгээ	198,645.61	5/5/2021	6/5/2024	26%
	Нийт		1,854,228.47			